



**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

ННА-67
ДАА-340
Э-807



F FIDELITAS
PARTNERS

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Судалгааны баг:

Багийн ахлагч: Б.Наранцэцэг
Судлаач: Б.Анирмаа
Б.Баялагмаа
Э.Энхцэцэг
Г.Амаржаргал

Хянан тохиолдуулсан: П.Бадамрагчаа

Тус судалгааны үр дүн, санал, зөвлөмж нь Фиделитас Партнерс ХХН-ийн судалгааны багийн дүгнэлт бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

@Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240.

Утас: 976-76113207

И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-9919-529-00-0

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	5
УДИРТГАЛ.....	6
НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИЛ ТОД БАЙДАЛ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ.....	9
1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлын зарчмын агуулга.....	9
1.2. Мэдэх эрх ба иргэний үндсэн эрх	13
1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах замаар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх нь.....	16
ХОЁР. ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН ХАНДАХ ЭРХ БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	21
2.1 Хэргийн оролцогчдын хандах эрхийг зохицуулсан байдал	21
2.2 Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын зохицуулалт, хэрэгжилт.....	23
2.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, ашиглаж буй технологийн шийдэл	28
ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ	35
3.1. Шүүхийн ил тод байдлыг хангах асуудал.....	35
3.2. Эрүүгийн хэргийн шүүхийн үйл ажиллагаан дахь "Ил тод байдал"-ын зарчмын хэрэгжилт	40
ДӨРӨВ. БУСАД УЛС ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ.....	45
4.1. Япон Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал, технологи ашиглахад баримталж буй бодлого	45
4.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдэх эрхийг хангасан байдал, технологийн шийдэл	48
4.3. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ил тод байдлыг хангах зарчмыг хуульд тусгасан байдал, технологийн шийдэл.....	51
4.4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мэдээллийн системийн ач холбогдол, технологийн шийдэл нэвтрүүлсэн сайн туршлага (АНУ, Австри Улс).....	58
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	65
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	69

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НМИТБтХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЦАтХ	Цагдаагийн албаны тухай хууль
ШтХ	Шүүхийн тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ӨМНӨХ ҮГ

Шударга ёсны салбарын ил тод, нээлттэй байдал нь шударга ёсыг бэхжүүлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд нэн чухал хүчин зүйл билээ. Шударга ёсны тогтолцооны гол институци болох шүүх эрх мэдлийн хараат бус, ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлэх чиглэлээр бодлогын дүн шинжилгээ өргөн хүрээнд хийгдэж, олон нийтийн хүртээл болж ирсэн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхээс өмнөх шатны оролцогч байгууллагуудын хараат бус байдал, процессын ил тод байдлын талаар хийгдсэн судалгаа дутмаг байна.

Иймд ННФ-ын захиалга, дэмжлэгээр "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал, хэрэгжүүлэх арга зам" бодлогын судалгааг Фиделитас партнерс ХХН-ийн хуульч, судлаачид хийж гүйцэтгэснийг үүгээр танилцуулж байна. Энэхүү судалгаа нь эрүүгийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд хэргийг ямар шалгуур, зарчмын дагуу нийтэд мэдээлэх боломжтойг судлан зөвлөмж санал болгож буйгаараа онцлогтой.

Судлаачид АНУ, БНСУ, ХБНГУ, Австри болон Япон Улсын эрүүгийн процессын ил тод байдлыг хангах платформ, технологийн шийдэл болон эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан нь энэ чиглэлээр цаашид бодлогын шийдэл эрэлхийлэхэд чухал хувь нэмэр болох мэдээлэл, дүн шинжилгээ боллоо гэж үзэж байна.

Эрүүгийн эрх зүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт хүний эрхийг баталгаатай эдлүүлэх, эрүүдэн шүүх болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх урьдчилсан нөхцөл болсон ил тод, нээлттэй байдлын зарчмыг хэрэгжүүлэх үйлсэд энэхүү судалгаа ахиц гаргана гэж найдаж байна. Судлаач, мэргэжилтнүүдийг судалгааны сэдвийн хүрээнд шүүмж хэлэлцүүлэг өрнүүлэх, өөрсдийн санал шийдлийг бидэнтэй хуваалцахыг урьж байна. Та бүхэн өөрийн санал хүсэлтээ ННФ-ын osf@forum.mn хаягаар болон байгууллагын нийгмийн сүлжээний хуудаст илгээнэ үү. Бидний ажлыг үргэлж дэмжиж, хамтран ажилладаг хараат бус судлаачид, уншигчдадаа талархал илэрхийлье.

П.Эрдэнэжаргал
Гүйцэтгэх захирал

УДИРТГАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (ЭХХША) хэрэгжүүлэгчид болох эрх бүхий албан тушаалтнуудад иргэний үндсэн эрхийг хязгаарлах эрх мэдэл хуулиар олгогдсон байдаг тул уг ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал чухал юм. Ил тод байдлын хэрэгжилт нь шүүх хурлын өмнөх болон шүүхийн ажиллагаанд мөрдөгдөж буй үндсэн зарчим, зохицуулалтаас хамааралтай¹. ЭХХША-ны нээлттэй байдал, хандах эрхийг олгосон байдал, ойлгомжтой тодорхой байдлын баталгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангахтай салшгүй холбоотой². ЭХХША-ны ил тод байдалд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох мэдээлэл хайх, хүлээн авах болон шударга шүүхээр шүүлгэх хүний үндсэн эрхүүдэд суурилсан үйл ажиллагааны ил тод байдал мөн хамаардаг³.

Хууль зүйн шинжлэх ухаанд ЭХХША-ны нээлттэй ил тод байдлыг 1) ЭХХША-ны нээлттэй, ил тод байдал нь тус ажиллагааны суурь зарчим мөн⁴; 2) ЭХХША-ны нээлттэй, ил тод байдлын зарчим нь зөвхөн шүүхийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангахад хамааралтай⁵; 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах нэг элемент нь нийтэд нээлттэй зохион байгуулалт гэхчилэн ялгаатай тайлбарладаг⁶.

Шүүх эрх мэдлийн ил тод байдал нь төрийн хууль дээдлэх зарчмын чухал элемент бөгөөд ардчилсан нийгэмд чухал ач холбогдолтой гэж хүлээн зөвшөөрөгддөг⁷. Шүүх эрх мэдлийн ил тод байдлын зарчим нь шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаа хэргийн оролцогчоос

¹ Nina S. Manova, Marina A. Baranova, Nikita V. Spesivov, "Transparency in Criminal Proceedings: Safeguarding the Interests of Society and State", 2022.

² О.П.Грибунов, В.Н.Гапонова, Е.В.Никифорова "Реализация принципа гласности в современном уголовном судопроизводстве", 2021.

³ Guilherme France, "Transparency of Court Proceedings", 2019.

⁴ Володина А.Н. "Гласность: правовая природа, содержание и проблемы реализации" дис. ...канд.юрид.наук, 2009, 267 с. дам эшлэв.

⁵ К.Ф.Гуценко "Уголовный процесс: учебник", 1998, 575с. дам эшлэв.

⁶ Батищев О.В. "Бинарная правовая природа общего начала гласности уголовного судопроизводства", Общество. Закон.Правосудие. 2020, №2, с.21–23. дам эшлэв.

⁷ Burkhard Hess and Ana Koprivica Harvey, "Open Justice in Modern Societies: What Role for Courts?", Open Justice: The Role of Courts in a Democratic Society, Nomos 2019, 9.

гадна, олон нийтэд ил тод, нээлттэй явагдах шаардлагатай гэх агуулгыг илэрхийлдэг. Уг зарчим нь шүүх, прокурор, цагдаа зэрэг хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд олон нийтээс хяналт тавих боломж олгож, мэдэх эрхийг хангахын сацуу тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой⁸.

Улс орнууд Үндсэн хууль болон олон улсын эрх зүйн хэмжээг тайлбарлан, уг зарчмын онолын үндэслэлийг хөгжүүлж, нээлттэй байх мэдээлэл, түүнийг хязгаарлах үндэслэл, процессын талаар зохицуулалтыг хууль тогтоомждоо тусгах замаар энэ зарчмыг хэрэгжүүлж байна. Ром-Германы эрх зүйн бүлийн үндсэн төлөөлөгч болох ХБНГУ-ын Шүүхийн эрх мэдлийн тухай суурь хуулийн 169 дүгээр зүйлд "Хувийн халдашгүй байх эрхийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд шүүх хуралдаан нээлттэй явуулна." гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон нийтэд нээлттэй байх зарчмыг зохицуулжээ⁹. Харин Англо-Саксоны эрх зүйн бүлд ЭХХША-ны хэрэгжүүлэгчид буюу цагдаагийн байгууллага, мөрдөн шалгах байгууллага, шүүхийн хүрээнд хаалттай буюу хязгаарлалт бүхий мэдээллээс бусад бүхий л мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод байхыг зорьдог¹⁰.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаажуулж, хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болохоор тодорхойлсон. Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж байна. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтад зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл нь хязгаарлалттай мэдээлэлд¹¹ хамаарахаар хуульчилсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (ЭХХШТХ) 3.2 дугаар зүйл, 34.4 дүгээр зүйлд шүүх хуралдааныг нээлттэй явуулах нөхцөлийг, мөн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.32-т шүүх эрх мэдлийн

⁸ 김진하, “‘민주적’ 법치국가에서의 사법”, 2017년도 법관연수 어드밴스 과정 연구논문집, 사법연수원 2018, 464

⁹ Gabriele Rose "Einfuehrung in das deutsche Strafprozessrecht", 2001,

¹⁰ Sarah Geraghty, Melanie Velez "Bringing transparency and accountability to criminal justice institutions in the South", https://law.stanford.edu/wp-content/uploads/2018/03/geraghty_velez.pdf

¹¹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна.

байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, олон нийтээс тавих хяналтыг шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр¹² дамжуулан хэрэгжүүлэхээр тусгасан. Харин шүүх хуралдааны үеэс бусад шатанд ЭХХША-ны явц, цуглуулсан мэдээлэлд хандах эрх оролцогчид хязгаарлагдмал байхын зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах эсэх нь прокурорын шийдвэрээс хамаарч байна.

ЭХХША-ны шүүхийн өмнө, шүүхийн болон шийдвэр гүйцэтгэх үе шатанд ил тод байдлыг хангах, мэдээлэлд авах эрхийг хангах талаар нэгдмэл зохицуулалт байхгүй. Улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмыг шүүх хуралдааныг нээлттэй явуулах агуулгаар явцуу тодорхойлох хандлага давамгайлж байгаагаас хэргийн оролцогчдод хандах эрхийг олгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ олон нийтэд нээлттэй, ил тод байх агуулга хэрэгжихгүйд хүрчээ.

Мөн манай улсад ЭХХША-ны ил тод байдлыг хангахад чиглэсэн нэгдмэл мэдээллийн систем хэрэглээнд нэвтрээгүй. Одоогоор олон нийт болон хэргийн оролцогчид хандах эрхгүй хууль сахиулах, прокурор болон шүүхийн байгууллагаас тус тусын дотоодын мэдээллийн системийг түлхүү ашиглаж байна.

Судалгаагаар ЭХХША-ны оролцогчдод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нээлттэй, ил тод, ойлгомжтой, хандах эрх олгогдсон эсэх, мөн шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хийгдэж буй ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байгаа эсэхийг судлах замаар ЭХХША-ны ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдох эрх зүйн асуудлуудыг тодорхойлж, мэдээллийн системийн тусламжтайгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж буй сайн туршлагуудад тулгуурлан өөрийн орны ЭХХША-ны ил тод байдлыг хангахад мэдээллийн системийг ашиглах боломжуудыг тодорхойлохыг зорьсон болно.

¹² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.32."шүүхийн иргэдийн төлөөлөгч" гэж шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэнийг;

НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИЛ ТОД БАЙДАЛ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

1.1. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЗАРЧМЫН АГУУЛГА

Монгол Улсад ЭХХША-ны ил тод байдлын талаарх ойлголтыг шүүх хуралдааныг нээлттэй явуулах буюу шүүхийн үйл ажиллагааны ил тод байдалтай холбон тайлбарладаг. ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.32-т зааснаар шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Иргэдийн төлөөлөгчөөс шүүх хуралдаанд оролцож, нотлох баримт шинжлэн судлахад асуулт тавих эрхийг хэрэгжүүлэх зохицуулалт нь ЭХХША-нд ил тод байдлыг хангаж буй явдал юм. Үүнтэй холбоотойгоор ЭХХША-ны ил тод байдал нь зөвхөн шүүхийн үйл ажиллагаагаар хязгаарлагдах эсэх, шүүхийн өмнөх шатанд ил тод байдлыг хангах эсэх асуултууд урган гарч ирдэг. Тиймээс ЭХХША дахь ил тод байдлыг хамрах хүрээг авч үзье.

Эрх зүйн онолын хүрээнд ил тод байдал (англ.хэл "Transparency")-ын зарчмыг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг сайжруулах мэдээллийн нээлттэй байдал гэж ойлгодог¹³. Ил тод байдлын зарчим нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээн авах, түгээн дэлгэрүүлэх¹⁴ буюу аливаа хэлбэрээр мэдээлэл авах эрх дээр суурилдаг¹⁵. Хууль тогтоогчоос ЭХХША-тай холбоотой мэдээлэл авах эрхийг тодорхой тохиолдолд хязгаарлах буюу ил тод байдлын байдлын зарчмын үзэл санааг хэрхэн тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой¹⁶. Европын

¹³ Kolosovich, M.S. 2019. Procedural means of ensuring transparency and secrecy in criminal proceedings: conceptual foundations (Doctoral Dissertation). Volgograd.

¹⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948.12.10.

¹⁵ Manova, N. S., Baranova, M. A., & Spesivov, N. V. 2022. Transparency in Criminal Proceedings: Safeguarding The Interests Of Society And State. In S. Afanasyev, A. Blinov, & N. Kovaleva (Eds.), State and Law in the Context of Modern Challenges, vol 122. European Proceedings of Social and Behavioural Sciences (pp. 418–423). European Publisher. <https://doi.org/10.15405/epsbs.2022.01.67>.

¹⁶ Ibis.

эрх зүйд ЭХХША-нд "publicity" буюу "нийтэд нээлттэй байдал"-ыг хангах нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн хамгийн чухал баталгаа гэж үздэг бөгөөд мөрдөн шалгах байгууллага, шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх, аливаа мэдээлэл хүртээмжтэй байхыг хамруулдаг¹⁷. Англо-Саксоны эрх зүйн системийн хүрээнд цагдаа, хуульч, тангарагтны шүүгч гэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, олон нийт нь ЭХХША-ны талаар болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэглэгдэж, мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын талаар мэдлэг олж авах гэх мэт зорилгын үндсэн дээр ЭХХША-ны ил тод байдлыг ханган ажилладаг¹⁸.

ЭХХША-ны ил тод байдал нь дан ганц шүүхийн үйл ажиллагааны ил тод байдал биш бөгөөд хэргийг шийдвэрлэх явцад хийгдсэн хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх бүх мэдээллийг олж авах нь энэ ойлголтоор баталгааждаг гэж үздэг¹⁹. Улмаар иргэд төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл авах, олж авсан мэдээллээ саадгүй ашиглах эрхтэй бөгөөд төрийн бүхий л байгууллагын үйл ажиллагаа ил тод байх ёстой тул түүний үр нөлөө нь ЭХХША-ны бүх үе шатыг хамаардаг байна²⁰. Тиймээс сүүлийн жилүүдэд ЭХХША-ны ил тод байдал гэдэгт шүүх хуралдааныг нээлттэй явуулах, хэргийн оролцогчдыг хэргийн бүх материалтай танилцах боломжоор хангах, ЭХХША-ны бүхий л үйл явц, мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн үйл ажиллагаанд олон нийтийн өргөн хяналт тавих боломж бүрдүүлэх буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль ёсны болон үр дүнтэй байдлыг хангах явдал гэж үзэж байна²¹.

ЭХХША явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх нь тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлэх, тэдэнд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Хууль сахиулах байгууллагад олон нийтээс хяналт тавих боломж олгох нь хууль сахиулах эрх бүхий албан тушаалтанд ёс суртахууны томоохон үүрэг, хариуцлага

¹⁷ Ibis.

¹⁸ https://law.stanford.edu/wp-content/uploads/2018/03/geraghty_velez.pdf

¹⁹ Gunin, D. I. 2008. Transparency and secrecy of information: a theoretical and legal aspect (Doctoral Dissertation). Ekaterinburg.

²⁰ Svezhintsev, E. I. 2017. Publicity as a means of public control over the activities of bodies carrying out criminal proceedings: international and Russian Aspects State and Law: Evolution, Modern Condition, Development Prospects (towards the 300th Anniversary of the Russian Police). St. Petersburg.

²¹ Manova, N. S., Baranova, M. A., & Spesivov, N. V. 2022. Transparency In Criminal Proceedings: Safeguarding The Interests Of Society And State. In S. Afanasyev, A. Blinov, & N. Kovaleva (Eds.), State and Law in the Context of Modern Challenges, vol 122. European Proceedings of Social and Behavioural Sciences (pp. 418-423). European Publisher. <https://doi.org/10.15405/epsbs.2022.01.67>

хүлээлгэж, хүний нэр төрийг гутаан доромжлох, хүч хэрэглэх, хэргийн оролцогчдыг илтэд үл хүндэтгэх, эрүүдэн шүүх зэрэг мөрдөн шалгах, шүүхийн байгууллагын албан тушаалтны ёс суртахуунгүй үйлдэл болоод хүчирхийллээс ангид байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл, ЭХХША нь ил тод, бодитой, шударга үнэлэлт дүгнэлт өгөх боломж бүхий нээлттэй байх тохиолдолд хэргийн оролцогчдыг аливаа албан тушаалтны харгис хэрцгий, хүний нэр төрийг гутаан доромжилсон, хүчирхийлэл хэрэглэсэн болон бусад ёс суртахуунгүй үйлдлээс хамгаалах боломжийг бий болгодог²².

ЭХХША-нд оролцогчдын эрх, эрх чөлөөнд халдаж болзошгүй мөрдөгчийн үйл ажиллагаа, шийдвэр нь хэргийн талаар сонирхсон бүхий л хүнд нээлттэй байх ёстой²³. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 45.6 дугаар зүйлийн 2-т зааснаар хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх талаар зохицуулсан хэдий ч энэ тохиолдолд хууль сахиулах байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн харилцах талаарх зохицуулалтын баримт бичиг олон нийтэд нээлттэй бус байна. Харин Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлохдоо мөрдөн байцаах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан үйлдлийг хамааруулж зохицуулсан. Үүнээс үзэхэд, таслан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг хуулийн дагуу хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээлсэн болон мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулсан үйлдлийг зааг ялгааг тодорхойлох шаардлага үүссэн бөгөөд тухайлсан тохиолдолд бүрд хуулийг нэгдмэл бус байдлаар хэрэглэх эрсдэлийг дагуулж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийн оролцогчдын эрхийг хязгаарласан, хориглосон шийдвэрийг цаг тухайд мэдээлэх нь процесс ажиллагааны үндэслэлтэй, хууль ёсны байх шаардлагыг хангах чухал ач холбогдолтой бөгөөд гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэх баталгаа болдог²⁴. Тиймээс ЭХХША-ны ил тод байдлын тухай ойлголт нь сонирхогч бүхий л этгээдэд ЭХХША-ны

²² Manova, N. S., Baranova, M. A., & Spesivov, N. V. 2022. Transparency In Criminal Proceedings: Safeguarding The Interests Of Society And State. In S. Afanasyev, A. Blinov, & N. Kovaleva (Eds.), State and Law in the Context of Modern Challenges, vol 122. European Proceedings of Social and Behavioural Sciences (pp. 418–423). European Publisher. <https://doi.org/10.15405/epsbs.2022.01.67>

²³ Ibis

²⁴ Ibis

талаарх мэдээллийг олж авах боломж олгох тогтолцоог бүрдүүлсэн байхыг шаарддаг.

Ил тод байдал нь Үндсэн хуулийн дагуу мэдээлэл хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх замаар төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж олгож, нөгөө талаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үндэслэлгүйгээр зөрчих, хязгаарлахаас сэргийлдэг. ЭХХША-ны шүүхийн өмнөх шатанд ил тод байдлын хамрах хүрээг тодорхойлоход дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

- Мөрдөн шалгах байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй албан тушаалтны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх;
- Мөрдөн шалгах ажиллагааны баримтлах хууль, дүрэм, журамтай танилцах боломж бүрдүүлсэн байх;
- Хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж болзошгүй мэдээллийг задруулахаас хамгаалагдсан байх²⁵;
- Таслан сэргийлэх болон албадлагын арга хэмжээний талаар ямар хэлбэрээр, хэрхэн мэдээлэх талаарх харилцааг журамласан байх;
- Мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичигт нэгдсэн байдлаар юуг хамруулах талаарх мэдээлэл тодорхой буюу нийтэд хүртээмжтэй байх;
- Ил тод байдлыг хангахад мэдээллийн технологийн шийдлийг хэрэгсэл болгон ашиглах тохиолдолд мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Ил тод байдлыг хангах хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг явуулж буй байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагын хариуцах чиг үүргийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын харилцааг журамлах зэрэг орно.

ЭХХША-ны шүүхийн өмнөх шатанд ил тод байдлыг хангахтай холбоотой мэдээлэл авах эрхийг хангах болон мөрдөн шалгах ажиллагааны нууцыг хадгалах үйл ажиллагааг хооронд нь харьцуулах, тэдгээрийн ач холбогдлыг эрэмбэлэх зэрэг нь төвөгтэй байдлыг үүсгэдэг. Улмаар тодорхой мөрдөн шалгах ажиллагааны үр нөлөөтэй байдал, түүнд оролцогчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагын улмаас ил тод байдлыг бүрэн хангах бололцоогүйг хүлээн зөвшөөрч байгаа²⁶ ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хүний

²⁵ Ibis

²⁶ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

эрхийг хязгаарласан аливаа үйлдэл, шийдвэр нь нийтэд нээлттэй байх нь зүйтэй. Үүний зэрэгцээ, шүүхийн өмнөх шатны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцлалыг зохистойгоор тэнцвэржүүлэх шаардлагатай байгааг судлаачид хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энэхүү тэнцвэртэй байдал нь гэмт хэргийг илрүүлэхэд оролцож буй хүмүүсийг дэмжих, иргэдийн хувийн мэдээллийн нууцлалыг хангах, мөрдөн байцаалтын явцын талаарх мэдээллийг сонирхсон этгээдэд авах боломжийг олгоход шаардлагатай²⁷.

1.2. МЭДЭХ ЭРХ БА ИРГЭНИЙ ҮНДСЭН ЭРХ

Мэдээллийн ил тод байдал нь мэдэх эрх, мэдээлэлд хандах эрхийг хангах, нээлттэй мэдээллийн санг үүсгэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зорилгоор хөрөнгийн мэдээллийг нийтэд ил болгох, төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх боломж бүрдүүлэхийг шаарддаг²⁸. Мэдэх эрх нь төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх, хүлээн авах иргэний үндсэн эрхэд багтах бөгөөд нээлттэй мэдээллийн сан нь төрийн байгууллагын мэдээлэлтэй чөлөөтэй танилцаж, түүнийг ашиглах, хуваалцах боломжийг олон нийтэд олгодог байна²⁹.

Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль 1992 онд батлагдсанаар хувь хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, иргэд үндсэн эрхээ баталгаатай эдлэх тогтолцооны үндэс болсон ардчилсан ёс тогтсон. Ардчилсан нийгэмд ард түмэн нь засаглах эрхтэй байж, төр ард түмний засаглах эрх мэдлээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ба олон нийтийн ашиг сонирхол, хүсэл зоригт тулгуурлан, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бий болгох үүрэг хүлээдэг. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д иргэний мэдэх эрх, мэдээлэл авах эрх чөлөөг суурь хуулиараа баталгаажуулжээ.

Үндсэн хуулиас гадна, олон улсын гэрээнүүдэд төрийн үйл ажиллагааны ил тод байх зарчмын хүрээнд хувь хүний мэдээлэл авах эрхийг дараах байдлаар баталгаажуулсан байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын³⁰ 19 дүгээр зүйлд заасны дагуу хүн бүр

²⁷ Manova, N. S., Baranova, M. A., & Spesivov, N. V. 2022, Transparency In Criminal Proceedings: Safeguarding The Interests Of Society And State. In S. Afanasyev, A. Blinov, & N. Kovaleva (Eds.), State and Law in the Context of Modern Challenges, vol 122. European Proceedings of Social and Behavioural Sciences (pp. 418–423). European Publisher. <https://doi.org/10.15405/epsbs.2022.01.67>.

²⁸ Council of Europe "Handbook on Transparency and Citizen Participation in Armenia", 2nd edition, 2020

²⁹ Ibis.

³⁰ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны 217 (III) тогтоолоор батлагдсан.

өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын³¹ 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. Үүнээс харвал, иргэний мэдэх эрх нь хүссэн мэдээллээ эрж хайх, олж авах, бусдад хуваалцах эрхийг багтаасан цогц эрх юм.

Мэдээллийг хайх, олж авах, түгээх үе шат нь бие биетэйгээ уялдаа холбоотой бөгөөд дээрх үе шатуудыг дамжиж мэдээлэл олон нийтэд хүрдэг. Мэдэх эрхээ цогцоор нь эдлэх боломжийг иргэдэд бүрдүүлж өгснөөр иргэд мэдээллийг үнэлж дүгнэх, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих болон маргаантай асуудлыг үндэслэлтэйгээр шүүмжлэх зэргээр засаглах эрхээ хэрэгжүүлэх үндэс суурь тавигддаг чухал ач холбогдолтой. Иргэдийн мэдээлэл авах эрх чөлөө нь олон нийтэд хамааралтай бүхий л үйл явцыг нээлттэй, ил тод байдлыг баталгаажуулдаг ардчиллын үндсэн хэмжүүрүүдийн нэг³² бөгөөд иргэний мэдэх, мэдээлэл авах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхэд төрөөс мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах зайлшгүй шаардлага үүсдэг байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн ил тод байдал нь шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхээс гарсан шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангахад оршдог. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлд зааснаар хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэхэд хуулийн дагуу байгуулагдсан шүүхээр нээлттэй шүүлгэх, мөн шүүхийн шийдвэр нийтэд нээлттэй байх шаардлагыг тодорхойлжээ. Үүнээс гадна, тус пактад ардчилсан нийгэм дэх ёс суртахуун, нийгмийн хэв журам буюу үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс эсхүл талуудын хувийн амьдралын эрх ашгийн үүднээс, эсхүл нээлттэй явуулах нь шүүн таслах ажлын эрх ашгийг зөрчинө гэж шүүхээс үзсэн онцгой нөхцөл байдалд, тэрхүү шүүхийн өөрийн саналаар зайлшгүй гэж тогтоосон хэмжээгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг шүүх ажиллагаанд бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт оролцуулахгүй байх, насанд хүрээгүй

³¹ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор батлагдсан.

³² М.Мөнхмандах. Иргэний мэдэх эрх ба төрийн нууцын зохицуулалт, 2011.

хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн эхнэр нөхрийн маргаан буюу хүүхдэд асран хамгаалагч тогтоохтой холбоотой шүүхийн шийдвэрийг нийтлэхгүй байх зэргээр "ил тод байдал"-ын хязгаарлалт түүний үндэслэлийг тусгасан байна.

Ил тод байдлыг хангах зарчим нь иргэний мэдэх эрхийг хэрэгжүүлэх баталгаа болохоос гадна, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд санал, гомдол гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх, хууль бус үйлдэл гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх зэрэг төрийн үйл ажиллагаа хууль ёсны байх зарчмын үндэс суурь болдог. Эрүүгийн шүүхийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангаснаар ЭХХША-ны шүүхийн өмнөх шатанд хамаарах үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчил, ёс зүйн болон мэргэжлийн хариуцлага алдагдах, олон нийтийн хяналтгүй байдал, хувийн ашиг сонирхлын зөрчилд өртөх зэрэг асуудлуудыг олж илрүүлж, учир шалтгааныг судлан шийдвэрлэхэд хангалтгүй юм. Тухайлбал, хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хориглосон шийдвэр хууль зүйн үндэслэлтэй эсэх, ЭХХША-нд хуульд нийцсэн дүрэм журмуудыг хэрэглэж буй эсэх, хууль бусаар цагдан хорих, баривчлах зэрэг хуульд нийцээгүй албадлагын арга хэмжээ, таслан сэргийлэх арга хэмжээнд хөндлөнгийн хяналт тавих замаар хууль бус шийдвэрийг бууруулж болох эсэх, хууль бус шийдвэр гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэж буй эсэх, түүнээс учирсан хохирлыг гаргуулсан эсэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарахгүй, ЭХХША-нд саад болохгүй бусад мэдээллийг нээлттэй болгох шаардлага үүсэж байна.

Шүүхийн өмнөх шат буюу мөрдөн шалгах ажиллагаанд иргэдийн эрх, эрх чөлөөнд хязгаарлах, хамгаалах процессын ажиллагааг хууль сахиулах байгууллага гүйцэтгэдэг тул шүүхийн өмнөх ЭХХША нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн жишигт нийцсэн, хуулийн дагуу журмаар үйл ажиллагаагаа явуулах ёстой бөгөөд иргэн бүрийн мэдээлэл авах эрхийг хангаж, мэдээллийг хүртээмжтэй байлгах, хүн бүр мэдээлэлтэй танилцаж, шаардлагатай хүсэлт, санал, гомдлыг эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх эрхийн баталгааг хангах нь зүйтэй.

ЭХХША-ны ил тод байдал нь аливаа сонирхогч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр мэдээлэл олж авах боломжийг хуулиар баталгаажуулсан дүрмийн тогтолцоо юм³³. Тиймээс "ил тод байдал" нь хууль сахиулах, прокурор, шүүхийн байгууллагын үйл ажиллагааг олон

³³ Mavlanov Kamoliddin Tuychievich. Ensuring Transparency in Criminal Procedure.2022. Tashkent State University of Law.

нийт, хуулийн мэргэжилтнүүд болон бусад оролцогч талууд ажиглаж, ойлгож, үнэлж дүгнэх боломжийг олгодог. Гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа байгууллага, хувь хүний хувийн мэдээлэл болон төрийн нууцыг хамгаалах тэнцвэрт байдлыг хангах нь зохистой.

1.3. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ЭХХША дахь ил тод байдал нь хууль сахиулах байгууллага болон иргэд хоорондын харилцааг ойртуулж, тухайн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлдэг³⁴. Мөн хууль сахиулах үйл ажиллагаанд хяналт тавих нэг арга бөгөөд ЭХХША-нд тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд тусалдаг байна³⁵. Угтаа ЭХХША-ны ил тод байдал нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр мэдээлэх хүлээн авах эрхийг баталгаажуулсан³⁶ олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоо гэж тодорхойлж болохоор байна. Шүүхийн ил тод байдал, шүүх хуралдааныг нээлттэй явуулах зэрэг нь ЭХХША-ны бүхий л үе шатанд хэргийн оролцогчдын хандах эрхийг олгох, олон нийтийн хяналтыг бэхжүүлэх арга зам биш юм. Тиймээс манай улсад ЭХХША-ны шүүхийн өмнө шатанд ил тод байдлын хангах, түүний хамрах хүрээ, хязгаарыг тодорхойлох шаардлага үүсэж байна.

ЭХХШТХ-д "ил тод байдал"-ыг хангах, олон нийтийн хяналтыг бэхжүүлэх зарчмыг тусгайлан зохицуулаагүй. Улмаар ЭХХША-ны шүүхийн өмнөх шатанд ил тод байдлыг хангах эсэх, хүний эрхийг хязгаарласан үйлдэл, шийдвэрийн талаар мэдээлэх эсэх нь эрх бүхий байгууллагын хүсэл зоригоос хамаарч байна. Тиймээс хэргийн оролцогчдын эрхийг хязгаарласан, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг тухай бүр мэдээлэх нь харилцан адилгүй болсноор тухайн байгууллагын гаргасан шийдвэрт хөндлөнгийн мониторинг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн хүрээлэнгийн Хууль зүйн зарчим, бодлогын баримт бичигт цагдаагийн байгууллага нь ЭХХША-тай холбоотой дараах мэдээллийг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх талаар тодорхойлсон. Үүнд:

³⁴ Mavlanov Kamoliddin Tuychievich "Ensuring transparency in criminal procedure", Web of Scientist: International Scientific Journal, Vol 3, Issue 5, May 2022, p.1550-1554

³⁵ Ibis.

³⁶ Ibis.

1. Гэмт хэргийн түвшин, бүртгэгдсэн гэмт хэрэг, дуудлагын тоо;
2. Албадлагын арга хэмжээ;
3. Хүч хэрэглэсэн талаарх мэдээлэл;
4. Цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлт, арга техник болон олон нийтийн санал гомдлын механизм;
5. Албан тушаалтны ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, агентлаг, албан тушаалтнуудын эсрэг гаргасан иргэний нэхэмжлэл, ЭХХША-г түдгэлзүүлэх тухай хүсэлт;
6. Байгууллагын бүтэц, ажил эрхлэлтийн стандарт, боловсон хүчний тоо, ажилтнуудын хүн ам зүй;
7. Эрэн сурвалжлах зөвшөөрөл, шүүхийн тандалтын тушаалын хүсэлт, гүйцэтгэсэн байдал;
8. Хамтын гэрээ хэлэлцээр;
9. Иргэний төлбөр тооцоо, шүүхийн шийдвэр зэрэг байна.³⁷

ЭХХША-ны ил тод байдал нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг хамгаалах хүрээнд хязгаарлагдана. Мэдээлэл хүлээн авах эрх нь төрийн, байгууллагын, хувь хүний нууцаар хязгаарлагддаг тул олон нийтэд ил болгосон тохиолдолд хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж, хохирол учруулах, мөрдөн шалгах ажиллагаанд саад болохуйц мэдээллийг нийтэд мэдээлэхгүй буюу мөрдөн шалгах ажиллагааны нууцыг хамгаалдаг. Тиймээс мөрдөн шалгах ажиллагааны нууцад ямар мэдээлэл хамаарах талаар хууль зүйн ойлголт, түүнийг баталгаажуулсан зохицуулалтыг шаарддаг. ОХУ-ын судлаач А.В.Крыловын тодорхойлсноор мөрдөн байцаалтын нууцад: 1) мөрдөн байцаалтын мэдээлэл; 2) сэжигтэн, яллагдагчийн оролцоогүйгээр мөрдөн байцаалтын ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримт; 3) хэргийн оролцогчдын аюулгүй байдлыг хангах хүрээнд авсан арга хэмжээ; 4) мөрдөн шалгах ажиллагааны тактикийн мэдээлэл; 5) мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй албан тушаалтны хэн болох, оршин суугаа газрын талаарх мэдээлэл; 6) гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл; 7) хэргийн оролцогчдын хамаатан садан, найз нөхөд хамаарал бүхий этгээдийн мэдээлэл тус тус хамаарна гэж үзжээ³⁸.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.8 дугаар зүйлд мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлалыг хамгаалах талаар, мөн хуулийн 29.3 дугаар зүйлийн 1-д зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт, үйл явц, үр дүнгийн нууцыг хангаж ажиллах

³⁷ <https://www.policingprinciples.org/chapter-1/1-05-transparency-and-accountability/>

³⁸ Mavlanov Kamoliddin Tuychievich "Ensuring transparency in criminal procedure", Web of Scientist: International Scientific Journal, Vol 3, Issue 5, May 2022, p.1550-1554

тухай тус тус зохицуулсан. Үүгээр хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны үйл явц, үр дүнгийн мэдээлэл нууц байх ерөнхий агуулгыг тодорхойлсон нь хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа бүхэлдээ хаалттай байх үндэслэл бий болдог. Улмаар мөн хуулийн 29.3 дугаар зүйлийн 5-д зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болох уян хатан бус зохицуулалттай. Прокуророос ямар шалгуур үзүүлэлтэд үндэслэн татгалзах буюу зөвшөөрөл олгохгүй байх үндэслэлийн талаар хуулиар тухайлан зохицуулаагүй.

ЭХХША-ны ил тод байдлыг хангаснаар олон нийтээс хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны нэгдсэн ойлголтыг мэдээлэл болгон авахын зэрэгцээ хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, зөрчигдсэн тохиолдолд гомдол шийдвэрлэх механизм сайжирна. Хэргийн оролцогчдын эрхийг хязгаарласан үр дагавар бүхий шийдвэрийг тэдгээрийн хүсэлтээр олон нийтэд нээлттэй болгох нь мөрдөн шалгах ажиллагааны хууль ёсны байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлэх эерэг үр дагавартай. Мөрдөн шалгах ажиллагааны шийдвэрт тавих хөндлөнгийн хяналт бодит биеллээ олж, хууль зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Ил тод байдлыг хэрэгжүүлэх хүрээнд шийдвэр гаргах үйл явцын талаарх мэдээллийг нийтэд нээлттэй болгосноор авлигын гэмт хэргийг илрүүлэх боломжийг олгодог бөгөөд шийдвэр гаргагчдыг ашиг сонирхлын зөрчилд орох, авлигын гэмт хэрэгт өртөх магадлалыг бууруулдаг³⁹. ЭХХША-нд хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчийг ашиг сонирхлын зөрчилд өртөх, хээл хахууль авах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхээс гадна энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгах боломжийг ил тод байдлын механизм нь нэмэгдүүлдэг байна. Улмаар мөрдөн шалгах ажиллагаа хууль ёсны байх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд тухайн хэргийн оролцогчид, иргэд болон иргэний нийгмийн байгууллагаас хөндлөнгийн хяналт тавьж, холбогдох гомдол, мэдээллийг хянан шалгуулах замаар авлигын гэмт хэргийг илрүүлэх байдалд эергээр нөлөөлнө.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц мэдээллийг нарийвчлан тодорхойлж, хуульд тусгаснаар бусад ЭХХША-тай холбоотой мэдээлэлд олон нийтээс хяналт тавих боломж нөхцөл бүрдэхээр байна. Олон нийтээс мэдээлэл авах эрхийн хүрээнд ил тод байдлыг бий

³⁹ UNODC "University Module Series: Anti-Corruption, Module 6: Detecting and Investigating Corruption", 2013 https://grace.unodc.org/grace/uploads/documents/academics/Anti-Corruption_Module_6_Detecting_and_Investigating_Corruption.pdf

болгосноор ЭХХША хууль ёсны байх зарчим хэрэгжих, хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтны мэргэжлийн хариуцлагыг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг зэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хөндлөнгийн хууль бус нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

ЭХХША-ны ил тод байдлыг хангах нь иргэн бүр мэдээлэл хүлээн авах эрхийг хэрэгжүүлж, мэдээлэлд хандах эрхийг нийтэд хүртээмжтэй байдлаар бий болгох үйл ажиллагааг мэдээлэл технологийн тусламжтайгаар гүйцэтгэж байна. Тухайлбал, нээлттэй өгөгдлийн сан, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх систем, ЭХХША-нд мөрдөж буй хууль тогтоомжтой танилцах боломжтой эрх зүйн мэдээллийн сан, шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан гэх мэт. Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах замаар манай улсад олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн мэдээллийн системийн хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсээр байгаа бөгөөд цаашид шүүхийн өмнө шатанд олон нийтийн хяналтыг бий болгох хүрээнд одоо байгаа системүүдийг шинэчлэн, сайжруулах шаардлага үүсэж байна.

ХОЁР. ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН ХАНДАХ ЭРХ БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

ЭХХША-ны мэдээлэл хүлээн авах, холбогдох хүсэлтийг гаргаж шийдвэрлүүлэх, процесс ажиллагааны талаарх мэдээллээр тасралтгүй хангагдах, хуулиар тодорхойлсон оролцогчдын хандах эрхийг баталгаажуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлын зарчмын хэрэгжилттэй хамааралтай.

ЭХХША дахь мэдээллийн ил тод байдалд хэргийн оролцогчдын хандах эрхийг хангаж буй байдал болон дотоод мэдээлэл эзэмшигч буюу хуулийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хамаардаг⁴⁰. Судалгааны энэ хэсэгт, шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэргийн оролцогчдын хандах эрх болон ЭХХША-ны хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн зохицуулсан талаар, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл хүртээмжтэй байгаа эсэх талаар авч үзье.

2.1 ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН ХАНДАХ ЭРХИЙГ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

ЭХХШТХ-д хэргийн оролцогчдын процесс ажиллагаанд хандах эрхийн хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

⁴⁰ Stephanos Bibas. Transparency and Participation in Criminal Procedure. 2006. Faculty Scholarship at Penn Carey Law.

Хүснэгт 1. Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан хэргийн оролцогчдын хандах эрхийн зохицуулалт

Яллагдагч	<ol style="list-style-type: none"> 1. ЭХХША-ны талаар шүүх, прокурор, мөрдөгчөөс энэ хуульд заасны дагуу өгөхийг зөвшөөрсөн мэдээллийг авах эрхтэй⁴¹. 2. Өөрийнх нь хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй⁴². 3. Шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцах эрхтэй⁴³.
Хохирогч	<ol style="list-style-type: none"> 1. Хэрэг бүртгэлтэй хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах эрхтэй⁴⁴. 2. Шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийг өөрт хамааралтай хэсэгт танилцах эрхтэй⁴⁵.
Иргэний нэхэмжлэгч, хариуцагч	<ol style="list-style-type: none"> 1. Хохирогч хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгт танилцах, нэмэлт ажиллагаа хийлгэх тухай хүсэлт гаргах эрхтэй.
Хэргийн оролцогч	<ol style="list-style-type: none"> 1. Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор гаргаж, шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, прокурор, оролцогчид танилцуулна⁴⁶. 2. Оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг түүнд танилцуулна⁴⁷.

Хэргийн оролцогчдын хандах эрхийн хамрах хүрээг тодорхойлсон зохицуулалтын дагуу ЭХХША-г хэрэгжүүлэгчид хүсэлт гаргаж, түүнийг шийдвэрлэсний үндсэн дээр мэдээлэлд хандаж, танилцах боломжтой. Харин ЭХХШТХ-иар танилцахыг зөвшөөрөөгүй мэдээллүүд нь хэргийн оролцогчдод хаалттай байна.

Хэргийн оролцогчийн хүсэлт, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгосон эсэхээс үл хамаарч ЭХХША-нд хамаарах мэдээлэлд

⁴¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1.

⁴² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 3.

⁴³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 4.

⁴⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.8.

⁴⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.13.

⁴⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.8 дугаар зүйлийн 1.

⁴⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.8 дугаар зүйлийн 5.

залруулга хийх нөхцөлийг ЭХХШТХ-ийн 45.6 дугаар зүйлийн 2-т заасан. Хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авсан, эмнэлгийн байгууллагад байлгасан ажиллагаа нь хууль бус болох нь нотлогдвол Хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалт явуулах байгууллага, Прокурор, Шүүх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр залруулга хийх үүргийг хуульчилжээ.

ЭХХШТХ-иар тодорхойлсон ЭХХША-ны ил тод байдлыг хангах зохицуулалт нь гол төлөв шүүхийн шатанд хамаарч байна. Шүүхээс өмнөх шатанд ил тод байдлыг хангах тодорхой зохицуулалтгүй байгаа нь хувь хүн, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгын хүрээнд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг хадгалахад чиглэгджээ. Тиймээс хуулиар ямар мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны нууц мэдээлэлд хамааруулахыг ерөнхийд нь бус мэдээллийг жагсаах байдлаар тодорхойлж, түүнд хамаарахгүй бусад мэдээлэлд хэргийн оролцогчдын хандах эрхийг нээлттэй байлгах нь зүйтэй.

2.2 ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

ЭХХШТХ-ийн 29.3 дугаар зүйлийн 2-т зааснаар мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалд дараах мэдээллийг хамааруулах бөгөөд прокурорын зөвшөөрсөн хэмжээгээр, түүний зөвшөөрөлд үндэслэн нийтэд мэдэгдэж болохоор зохицуулжээ. Үүнд:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явц;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үр дүн;
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх төрийн нууц мэдээлэл⁴⁸;
- Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл⁴⁹;

⁴⁸ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.1.

⁴⁹ Төрийн болон албан нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.2.

- Хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хувь хүний эмзэг мэдээлэл⁵⁰ хамаарна.

Дээрх агуулгаас харахад хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны бүхий л мэдээллийг нууцлалд хамааруулж, нууцлагдсан мэдээллийг гагцхүү прокурорын зөвшөөрлөөр нийтэд мэдэгдэхээр өргөн хүрээнд зохицуулсан нь мөрдөн шалгах ажиллагааны ямар мэдээллийг прокурор зөвшөөрөл олгосон эсэхээс үл хамаарч ил тод байлгахыг тодорхойлоход бэрхшээлтэй байдал үүсэж байна.

Судалгааг гүйцэтгэх явцад, ЭХХШТХ-ийн 29.3 дугаар зүйлийн 5-д заасны дагуу прокурорын зөвшөөрлөөр нийтэд мэдээлсэн буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг "ил болгосон"-той холбоотой өмнөх онуудад хамаарах нэгдсэн тайлан, нэгдсэн мэдээллийг ЭХХША-ны хэрэгжүүлэгч байгууллагуудын <https://police.gov.mn/p/3889>, <https://prokuror.mn/> цахим хуудаснуудад хайлт хийсэн боловч, илэрц гарч ирээгүй. Хууль сахиулах байгууллагаас ЭХХША-ны ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа болон хангасан талаарх тайлан, нэгдсэн мэдээллийг хүртээмжтэй байдлаар байршуулснаар, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх боломж бүрдэх болохыг анхаарах нь зүйтэй.

ЭХХШТХ-д прокурорын хяналттай холбоотой мэдээлэл ил тод байх талаар тухайлсан зохицуулалт байхгүй. Тиймээс прокурорын зөвшөөрлөөр хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахаар авч буй арга хэмжээний хууль ёсны байдал, зүй ёсны процедур шаардлагыг хангаж буй эсэх, авч буй албадлагын болон таслан сэргийлэх арга хэмжээ нь зорилгодоо тохирсон эсэх зэрэгт олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй.

ЭХХШТХ-иас гадна, Цагдаагийн албаны тухай хууль, Прокурорын тухай хууль болон хуульд үндэслэн батлагдсан холбогдох журмуудыг ЭХХША-нд дагаж мөрддөг. Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газраас баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг⁵¹ мөрдөн шалгах ажиллагаанд баримталж, Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан Прокурорын хяналт аргачилсан заавар, журмын⁵²

⁵⁰ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11.

⁵¹ Нийтэд нээлтэй бус, албан бус эх сурвалжийг оруулав. https://www.academia.edu/38190905/%D0%A6%D0%91%D2%AE%D0%90%D0%96_%D0%BA%D0%BE%D0%B4_pdf

⁵² Нийтэд нээлттэй бус, албан хэрэгцээнд ашиглагддаг. Уг журам, зааврыг батлах хууль зүйн үндэслэлийг Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 1.6-д заасан.

дагуу прокурорын хяналтыг хэрэгжүүлдэг. Эдгээр эрх зүйн актууд нь мөрдөн шалгах ажиллагаа болон прокурорын хяналтыг явуулах, хэргийн оролцогчидтой харилцахад баримтлах гол эх сурвалж болдог. Гэтэл дээрх эрх зүйн актууд нь нийтэд хүртээмжтэй бус, гагцхүү мөрдөгч, прокурорын албан хэрэгцээнд ашиглагдах баримт бичиг гэж үзэж, эрх зүйн актын ил тод байдлыг хангадаггүй. ЭХХША-ны шүүхийн өмнөх шатанд хэрэглэж буй эдгээр эрх зүйн актуудад оролцогчдын хандах эрх хаалттай, хүртээмжтэй бус байгаагийн улмаас эрх зүйн актууд нь хуульд нийцэж буй эсэх, эдгээр актуудыг үндэслэж, хуулиас давсан хүний эрхийг хязгаарлах үйлдлийг гаргаж буй эсэхийг хянаж, хууль зүйн дүгнэлтийг тухай бүр хийх боломжгүй байхын зэрэгцээ эдгээр журмуудын хүрээнд авсан арга хэмжээтэй холбоотой гомдлыг хэргийн оролцогчдоос гаргах, түүнийг шийдвэрлүүлэх боломж хязгаарлагджээ.

Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх талаар 2020 онд хийгдсэн судалгааны тайланд 1) дүн шинжилгээ хийсэн 132 журмын 14 журмын үйлчлэл дотогшоо чиглэсэн; 2) хууль тогтоомж, хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцүүлэх үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай 87 журам байна; 3) цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь эрх зүйн эх сурвалжийн хувьд захиргааны хэм хэмжээний акт мөн эсэх нь онолын хувьд судлаачдын дунд маргаантай байдаг бөгөөд энэ талаар тухайлан судлах нь журмын цаашдын шинэчлэлд чухал ач холбогдолтой талаар дурдсан байна⁵³. ЭХХША-нд дагаж мөрдөж байгаа эрх зүйн актуудын ил тод байдлыг хангаагүйн улмаас гарч буй үр дүн нь дээрх судалгааны дүгнэлтээр тодорхойлогдож байна. Цагдаагийн үйл ажиллагааны журмуудын тухайлсан кодуудад хандах эрх хаалттай байгаа нь хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлийг үүсгэж байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь кодчилсон бүтцээс бүрдэх бөгөөд бүхэлдээ цагдаагийн байгууллагын дотоод зохион байгуулалтыг зохицуулсан хэм хэмжээ биш учраас байгууллагын дотоод бүтэц зохион байгуулалтад чиглэсэн кодуудыг ЭХХША-нд баримталж буй кодоос ялган зааглах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам төдийгүй Улсын Ерөнхий прокуророос дангаар болон хамтран баталсан гадагш чиглэсэн буюу ЭХХША-нд баримталж, хэргийн оролцогчидтой харилцаж буй аливаа эрх зүйн актуудын хандах эрх нээлттэй буюу хүн бүр танилцах боломжтой байхаар байршуулах нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

⁵³ ННФ, Дотоод хэргийн их сургууль "Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж бус эсэх" судалгааны тайлан, 2020.

Прокурорын байгууллага нь үйл ажиллагаандаа 1) хуулийг нэг мөр хэрэглэх, 2) хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, 3) нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, 4) хараат бус, бие даасан байх, 5) ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална. Прокурорын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т тус тус зааснаар хуулиар нууцлахаар тогтоосноос бусад асуудлаар гаргаж байгаа прокурорын шийдвэр ил тод байхаар хуульчилсан. Улмаар хуулиар нууцлахаар тогтоосон прокурорын шийдвэрт дараах ажиллагааг хамааруулж үзэж болохоор байна. Үүнд:

- Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна (ЭХХШТХ 1.4.1.10).
- Мөрдөгч хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг тогтоох зорилгоор орон байранд нэвтэрч, хяналт тогтоох, орон байрнаас бусад газарт нэвтэрч, хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд нэвтэрч, хяналт тогтоох ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна (ЭХХШТХ 26.3.1).
- Хяналттай хүргэлт-Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхэд оролцсон хүнийг олж тогтоох зорилгоор хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна (ЭХХШТХ 26.5.1).
- Хяналтын худалдан авалт-Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан авах, эсхүл худалдан авахаар хэлцэл хийх ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна (ЭХХШТХ 26.6.1).
- Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно (ЭХХШТХ 26.1.2).
- Харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно (ЭХХШТХ 26.2.2).
- Харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох гаргуулж авах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр

нууцаар явуулж болно (ЭХХШТХ 26.2.2).

ЭХХША-ны явцад прокурорын зөвшөөрлөөр нууц ажиллагаа явуулахтай холбоотой дээрх шийдвэрүүд нь нээлттэй байх мэдээлэл хамаарахгүй. Харин Прокурорын тухай хуулийн 8.2-т зааснаар ЭХХША-ны явцын талаарх мэдээллийг олон нийт, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд өгөхдөө 1) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эсэх, 2) хуулиар хориглосон эсэхийг шалгаж, гагцхүү прокурорын зөвшөөрлөөр олгоно. Прокурорын тухай хуулиар прокурорын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлсэн нь ЭХХША-ны ил тод байдлыг хангах замаар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой байна. Гэхдээ ЭХХША-ны явцын талаарх мэдээлэл "нээлттэй байх" эсэх нь прокурорын зөвшөөрлөөс хамаарах журмыг мөн баримталжээ.

Цагдаагийн алба, албан хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална. Хуулиар тодорхойлсон цагдаагийн алба, албан хаагчийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчим нь ЭХХША-ны ил тод байдлыг хангахтай салшгүй холбоотой юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн (ЦАТХ) 64 дүгээр зүйлийн 64.7-д цагдаагийн байгууллага зохих сургалтад хамрагдаж тэнцсэн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх үүрэгтэйгээр тусгайлан томилж, хамтран ажиллахаар зохицуулсан. Энэ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг нийтэд үнэн зөвөөр хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах суваг нээж байна.

ЦАТХ-д заасан дараах мэдээллийг бусдад задруулах, тараах, олон нийтэд түгээхийг хориглосон. Үүнд:

- Төрийн байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн цагдаагийн байгууллага, албан хаагчийн болон халхавчлах үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл (ЦАТХ 65.9);
- Хуульд зааснаас бусад тохиолдолд цагдаагийн албан хаагч хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой мэдээллийг хайх, цуглуулах, хэрэглэх, тараах (ЦАТХ 68.5);
- Бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрд хохирол учруулж болзошгүй мэдээ, мэдээлэл (ЦАТХ 69.1.3);
- Төрийн болон албан нууц, байгууллагын нууц, хүний эмзэг


мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээлэл (ЦАТХ 69.1.4) зэрэг хамаарна.

Хуулиар хориглосон бусад цагдаагийн алба, албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүлээн авах эрхийг хуулиар тодорхойлсон нь ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

2.3 ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АШИГЛАЖ БУЙ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

Хэрэг бүртгэлт эхэлснээс хойш хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл "мэдээллийн ил тод байдал"-ыг хангах чиг үүргийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгч болох мөрдөгч, прокурор, шүүх хариуцан хэрэгжүүлдэг.

Зураг 1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ил тод байдлыг хангах субъектүүд



Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 18 дугаар тогтоолоор хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авахыг даалгасан. Үүнд:

- Хүн ямар хэрэгт яллагдаж байгаага мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаас татсан талаарх тогтоолыг гардуулах өгөх зохицуулалтыг хуульд тусгах;
- Шүүгч, прокурор, мөрдөгч нь ЭХХШТХ-ийн 16.10 дугаар зүйлийн 4-д заасан хүсэлтийг хангахаас татгалзаж байгаа үндэслэлийг тухайн шийдвэртээ тодорхой тусгах асуудлыг хуульчлах;
- Төрийн нууцад хамаарах, мэдээлэл агуулсан шүүх, прокурорын

шийдвэрийг оролцогчид танилцуулах, гардуулан өгөх журмыг нарийвчлан зохицуулах;

- Хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаанд шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмыг боловсронгуй болгох гэх мэт.

Дээрх тогтоолын хүрээнд холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх ажлууд энэ судалгааг гүйцэтгэх хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад шүүхийн захиргаа голлох чиг үүргийг гүйцэтгэдэг. Манай улсын хувьд анх 2012 онд Шүүхийн захиргааны бие даасан хуулийг баталж, шүүхийн захиргааны чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, шүүхийн захиргааны ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах болсноор бие даасан шүүхийн захиргааны загварыг бий болгосон. Гэхдээ 2021 онд Монгол Улсын Шүүхийн тухай хууль (ШТХ)-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар шүүхийн захиргаатай холбоотой асуудлыг тус хуулиар нэгтгэн зохицуулж, Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсон юм.

Шүүхийн захиргааны хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг АНУ-ын Шүүхийн захиргааны үндэсний холбооноос гаргасан материалд⁵⁴ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

• **Мэдээллийн удирдлагын чиг үүрэг (Information management):**

Энэ чиг үүрэг нь шүүхийн захиргааны ажилтнуудыг шаардлагатай мэдээллээр хангах, өмгөөлөгч, хэргийн оролцогч, төрийн захиргааны байгууллага, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах чадавхыг бэхжүүлэх зорилготой⁵⁵. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т зааснаар шүүхийн захиргаа буюу Шүүхийн Ерөнхий зөвлөл, шат шатны шүүхийн Тамгын газар нь олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийг дараах байдлаар гүйцэтгэхээр зохицуулжээ. Үүнд:

- Шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг захиргааны удирдлагаар хангах, шүүгчийг шилж олох, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлэх (ШТХ 75.2.1);
- Шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудаст тогтмол байршуулах (ШТХ 75.2.2);

⁵⁴ Шүүхийн судалгаа, мэдээллийн төв "Шүүхийн захиргааны чиг үүрэг" харьцуулсан лавлагаа, 2-р тал

⁵⁵ Мөн тэнд.

- Мэдээлэл, лавлагааны үйлчилгээг зохион байгуулах (ШТХ 75.2.4);
- Шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулах (ШТХ 75.2.5);
- Шүүхийн цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх (ШТХ 75.2.3) зэрэг хамаарна.

• **Иргэдийн төлөөлөгчийн удирдлагын чиг үүрэг:**

Энэ чиг үүрэг нь шүүн таслах ажиллагаан дахь иргэдийн оролцоо, үр нөлөөг бий болгох чухал ач холбогдолтой. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 1.4.1.32, 3.4-д тус тус зааснаар иргэдийн төлөөлөгч нь эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгыг хангах гол оролцогч нь байдаг. Иргэдийн төлөөлөгч нь 1) шүүх хуралдааны явцад нотлох баримт шинжлэн судлахад оролцож, шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр асуулт тавих, 2) шүүгчийн гэм буруугийн талаар санал бичиж, уншиж сонсгох эрхтэйгээр шүүх ажиллагаанд оролцож байна.

Иргэний мэдэх эрхийг хангах, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2011 онд төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах харилцааг зохицуулах зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хуулийг баталсан⁵⁶. Улмаар манай улсад өрнөж буй төрийн үйл ажиллагааны цахим шилжилтийн хүрээнд төрийн үндсэн болон дэмжих системийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор тус хуулийг шинэчлэн найруулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль" (НМИЛБТХ) нэртэйгээр баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн юм. Уг хууль нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой. Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д зааснаар Мэдээлэл хариуцагч⁵⁷ нь дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй

⁵⁶ <https://legalinfo.mn/mn/detail/374> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцно.

⁵⁷ Нийтийн мэдээллийн тухай хуулийн 6.1-т зааснаар мэдээлэл хариуцагчид төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд, хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, олон нийтийн радио, телевиз, улс төрийн нам хамаарна.

байлгана. Үүнд:

1. Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээлэл (НМИТБтХ 8.2)
2. Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх мэдээлэл (НМИТБтХ 8.3)
3. Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл (НМИТБтХ 8.4)
4. Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл (НМИТБтХ 8.5)
5. Бусад мэдээлэл буюу үүнд шүүн таслах ажиллагааны дүн мэдээ хамаарна (НМИТБтХ 8.6).

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.14-д заасны дагуу Мэдээлэл хариуцагч буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд нь шүүн таслах ажиллагааны дүн мэдээг нийтэд ил тод байлгах үүргийг хүлээдэг. Уг зохицуулалтын хэрэгжилтийг хангах хүрээнд шүүхээс шүүн таслах ажиллагааны дүн мэдээг сар, улирал, жилийн давтамжтайгаар гаргахаас гадна жил бүр нэгдсэн Шүүхийн тайланг гаргаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн албан ёсны веб сайтад цахим хэлбэрээр байршуулж байна. Цагдаагийн байгууллагын хувьд тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээг бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдсэн байдал, гэмт хэрэг үйлдсэн газар, гэмт хэрэг үйлдэгсэд, гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээд, учирсан хохирол, бүртгэгдсэн зөрчил зэргээр төрөлжүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны сайтад олон нийтэд нээлттэй байдлаар байршуулдаг. ЭХХША-тай холбоотойгоор нээлттэй байршуулж буй мэдээлэл нь тоон мэдээллийг хамардаг бөгөөд процесс ажиллагааны явцад гарсан шийдвэр, үйл ажиллагааны мэдээлэл багтдаггүй.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т зааснаар гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл нь "хязгаарлалттай мэдээлэл"-д хамаардаг. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана" хэмээн заасны дагуу гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад олж авсан мэдээлэл нь нээлттэй байлгах боломжгүй хязгаарлалттай

мэдээлэлд хамаарах тул энэхүү мэдээллийг Мэдээллийн эзний зөвшөөрлөөр эсхүл хуульд заасан үндэслэл журмын дагуу бусдад дамжуулах боломжтой юм.

Цагдаагийн байгууллага нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3-т зааснаар гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Харин Мал хулгайлах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д зааснаар Нутгийн захиргааны байгууллага нь алдуул малыг бүртгэж, алдуул малын талаар цагдаагийн байгууллагын болон олон нийтэд мэдээлж байх үүрэгтэй.

ЭХХША-ны явцад цугларсан мэдээлэл нь нийтэд нээлттэй бус "хязгаарлалттай мэдээлэл"-д хамаарах бөгөөд зөвхөн шүүн таслах ажиллагааны дүн мэдээ, гэмт хэрэг, зөрчил холбогдох тоон мэдээлэл нийтэд нээлттэй байхаар тусгагдсан. Үүнтэй холбоотойгоор шүүхийн болон цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, шүүн таслах ажиллагааны тоон статистик мэдээллийг нийтэд нээлттэй хэлбэрээр өөрсдийн албан ёсны вебсайтад байршуулж хэвшсэн байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар нийтийн мэдээллийн дэд бүтэц нь дараах системүүдээс бүрддэг. Үүнд:

1. Үндсэн систем буюу ХУР. Төрийн мэдээлэл солилцооны систем. Уг системээр дамжуулан төрийн байгууллага хоорондоо, төрийн байгууллагаас хувийн хэвшил хоорондоо мэдээлэл солилцох зорилгоор ашиглах боломжтой.
2. Дэмжих системүүд буюу ДАН, E-sign, Digidoc, E-mongolia зэрэг үндсэн систем болон төрийн байгууллагын системийн хэвийн, найдвартай, ажиллагааг хангахад чиглэсэн системүүд хамардаг.
3. Мэдээлэл хариуцагчийн буюу төрийн байгууллагын бие даасан мэдээллийн систем.
4. Мэдээллийн сүлжээ болон нийтийн мэдээллийн сан орно.

Дээрх мэдээллийн системүүд нь хоорондоо ХУР системийн тусламжтайгаар мэдээлэл солилцдог. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолоор батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглах үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-д заасан шаардлагыг хувийн хэвшил нь хангасан тохиолдолд хувийн хэвшлийн системээр дамжуулан ХУР системийг ашиглаж, төрийн мэдээллийг хүлээн авах, солилцох боломжтой.

Нийтийн мэдээллийн дэд бүтцэд Цагдаагийн байгууллага, Зам тээврийн асуудал хариуцсан байгууллагын систем холбогдсон бөгөөд хувь хүн төрийн үйлчилгээний e-mongolia нэгдсэн системээр дамжуулан өөрт хамаарах лавлагаа, мэдээлэл гаргуулах боломжтой. Гэхдээ уг лавлагаа өмнө нь шийдэгдсэн эрүүгийн хэрэг, зөрчилтэй холбоотой бөгөөд эрүүгийн журмаар одоо хянан шийдвэрлэгдэж буй мэдээллийг хэргийн оролцогчдоос авах боломжгүй.

Цагдаагийн байгууллага, Прокурорын байгууллагаас хоорондоо эсхүл төрийн бусад байгууллагад хүсэлт илгээх, мэдээлэл гаргуулах, албан бичиг солилцоход төрийн албан бичиг солилцооны Digidoc системийг ашигладаг байна. Цагдаагийн байгууллага нь "Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан", Прокурорын байгууллага нь зөрчлийн хэрэг бүртгэлт, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагаа, шүүхэд төрийг төлөөлөх ажлын чиглэлээр статистик үзүүлэлт гаргах, дүн шинжилгээ хийх зорилгоор "Цахим бүртгэлийн нэгдсэн систем"⁵⁸-ийг тус тус ашиглагддаг. Эдгээр хоёр мэдээллийн системд хэргийн оролцогч болон олон нийтээс хандах эрх нээлттэй биш, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд зориулагдсан систем юм.

Цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллагыг холбосон www.e-Justice.mn цахим мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн боловч өнөөдрийг хүртэл олон нийтийн хялбар хэрэглээ болж чадаагүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээллийг хэргийн оролцогчдод шуурхай хүргэх нь хуулийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.⁵⁹ Тус систем нь хэргийн оролцогч хувь хүн нэвтрэх эрхтэй бөгөөд албан ёсны и-мэйл хаягийг хэрэглэх, өмгөөлөгч, төрийн эрх бүхий албан тушаалтнууд тусгай и-мэйл хэрэглэх шаардлага тавигдахгүй. Системийн Хэрэглэгч нь хувь хүн байхаар хязгаарлагдсан учир өмгөөлөгч өөрийн эрхээр нэвтэрч хэргийн нөхцөл байдалтай танилцах боломжийг хязгаарлагдсан. Үүнтэй холбоотой өмгөөлөгчдийн дунд 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл тус системийг ашиглаж буй талаар, эсхүл ашиглах оролдлого хийж байсан эсэх талаар явуулсан санал асуулгын үр дүнд "хэрэглэдэггүй" гэсэн хариу үр дүн гарчээ⁶⁰. Нэг талаас эрх бүхий

⁵⁸ Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын 2024.06.27-ны өдрийн 7/5425 тоот "Хариу өгөх тухай" албан тоотод дурдсан мэдээлэл.

⁵⁹ <https://www.e-justice.mn/>

⁶⁰ МХХ, МӨХ-оос хамтран зохион байгуулсан "Дижитал шилжилт ба өмгөөлөгч" сэдэвт хэлэлцүүлэгт танилцуулсан өмгөөлөгч Д.Отгонбатын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цахимжилт, хүний эрхийг хангах нь" сэдэвт үзүүлэн илтгэл.

албан тушаалтан, нөгөө талаас зөвхөн хувь хүн хандах эрхтэй байх систем хөгжүүлсэн нь хууль зүйн туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимаар оролцох боломж хязгаарлагдаж, олон нийтэд нээлттэй мэдээлэл байршуулах хэсэг бүрэн хөгжөөгүй нь олон нийтээс хяналт хэрэгжүүлэх, мэдэх эрхээ эдлэх боломж хязгаарлаж байна.

Манай улсад мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийн системтэй харьцуулахад шүүхийн мэдээллийн систем нь олон мэдээллийн системүүдийг хамаарах ч нэгдсэн биш байгаа нь мэдээллийн ялгаатай байдал бий болох эрсдэлийг дагуулдаг. Мөн шүүх, шүүхийн тамгын газарт 20 гаруй систем, программ хангамж хэрэглэгдэж байгаа⁶¹ боловч хэргийн оролцогч руу гадагш чиглэсэн, ЭХХША-ны ил тод байдлыг хангасан систем цөөхөн байна. Тухайлбал, эрүүгийн хэргийн бүртгэлийн хяналтын нэгдсэн системд зөвхөн эрх бүхий албан тушаалтнууд хандах эрхтэй, харин хэргийн оролцогчид, өмгөөлөгч, олон нийтэд хандах эрх олгогдоогүй.

Тиймээс одоо ашиглаж буй ЭХХША-ны системд хандах эрх бүхий этгээдийг оновчтой тодорхойлох, нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй бүрэн холбогдсон систем ашиглаж, цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллагын олон системүүдийг хооронд нь холболт хийх замаар өгөгдлийг үнэн зөв байдлыг хангах нь зүйтэй. Цаашлаад эрх бүхий албан тушаалтан, хэргийн оролцогчид, олон нийтээс хандах боломжтой эрүүгийн хэргийн мэдээллийн нэгдсэн систем үүсгэж, ЭХХША-ны ил тод байдлыг хангах боломжтой байна.

⁶¹ Шүүхийн Ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан – 2022", 14-р тал.

ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ

3.1. ШҮҮХИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ

ЭХХША-ны ил тод байдлыг хангах асуудал нь шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахтай салшгүй холбоотой. Шүүхийн ил тод байдал гэх ойлголт нь "Шударга ёсыг олон нийтийн өмнө хэрэгжүүлэх ёстой"⁶² гэх агуулгыг хамаардаг. Эрүүгийн хэргийн шүүхийн үйл ажиллагаа ил тод байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17-д заасан мэдээлэл хайх хүлээн авах эрхийг хангахын зэрэгцээ шүүхийн үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах замаар шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Шударга ёсыг олон нийтийн өмнө хэрэгжүүлэх нийтлэг шаардлага нь дараах агуулгыг багтаадаг. Үүнд: 1) шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй явуулах, 2) нотлох баримтыг нийтэд мэдээлэх, 3) шүүх хуралдааны талаар шударга, үнэн зөв, цаг үеэ олсон мэдээлэл өгөх нь шүүхийн аливаа үйл ажиллагаанд саад болохгүй⁶³ гэх агуулга хамаарна.

Шударга ёсыг олон нийтийн өмнө хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын ЭХХШТХ-д дараах зохицуулалтыг тусгасан: 1) төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийн хамгаалах шаардлагатай, өсвөр насны ялагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шат шүүх хуралдааныг нээлттэй явуулна; 2) шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны явцад нотлох баримт шинжлэн судлахад оролцож, шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр асуулт тавих эрхтэй; 3) хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан,

⁶² House of Commons Justice Committee, Open justice: court reporting in the digital age /Fifth Report of Session 2022–23/ October 2022 p4

⁶³ Judicial College, Reporting Restrictions in the Criminal Courts April 2015 (2016) p4.

эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн мэдээлэлдээ залруулга хийж, шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Шүүхэд өгсөн нотлох баримтыг нийтэд ил мэдээлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч Монгол Улсын ЭХХШТХ-д тодорхойлсноор шүүх хуралдааны нотлох баримтыг шинжлэх судлахад иргэдийн төлөөлөгч оролцуулна. Үүнээс гадна, шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтлэх, шүүхэд өгсөн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах⁶⁴ нь ил тод байдалд хамаарна. Шүүгчдийн хувьд өөрийн байр суурийг шийдвэрээрээ дамжуулан илэрхийлэх бөгөөд шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх эсхүл олон нийтэд зориулсан мэдэгдэх гаргах зэргээр тайлбар гаргах нь зохимжгүй гэж үздэг⁶⁵. Тиймээс Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д анхан, давах, хяналтын шатны шүүхээс гарсан шийдвэрүүдийг нээлттэй байршуулж, Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэх журмын⁶⁶ дагуу шүүхийн шийдвэрийг эрүү, иргэн, захиргааны хэргийн төрөл, эрх зүйн асуудлын агуулга зэргээр төрөлжүүлэн сонгож улирал тутам "Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл" гаргаж байна.

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын зорилго нь шүүхээс шударга ёсыг хэрэгжүүлж байгаа эсэх талаар олон нийт өөрийн дүгнэлтэд хүрэх боломжийг хангах явдал юм. Олон нийт шүүх хуралдаанд оролцох эрхгүй, шүүх хуралдааны талаарх мэдээллийг олж авах боломжгүй бол шүүхэд итгэх итгэлийг баталгаажуулж чадахгүйд хүрнэ⁶⁷. Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмжийн⁶⁸ 9-д дурдсанаар шүүхийн тогтолцооны талаар иргэдийн төсөөлөл, туршлага зэрэг нь тухайн иргэний өөрийнх нь хэргийн оролцогч, гэрч, тангарагтан, иргэдийн төлөөлөгч зэргээр шүүхийн ажиллагаанд байсан туршлагаар хязгаарлагддаг. Тиймээс хэргийг сонирхсон хүмүүс, олон нийт, хэвлэл мэдээллийнхэн шүүхийн үйл ажиллагаанд юу болж байгааг

⁶⁴ R (Mohammed) v Foreign Secretary [2011] QB 218; R (Guardian News & Media) v City of Westminster Magistrates Court [2013] QB 618

⁶⁵ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

⁶⁶ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 11-р сарын 18-ны өдрийн 326 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэх журам.

⁶⁷ Ed Owen (committees.parliament.uk/writtenevidence/40141/html/)

⁶⁸ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 6 дугаар хурлаар батлагдсан.

мэдэх эрхтэй байна.

Англи болон Уэлсэд шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын хамрах хүрээг хууль тогтоогч болон шүүхээс дараах байдлаар тодорхойлжээ. Шүүхийн нээлттэй, ил тод байдал нь шүүхээс хэргийг шийдвэрлэх гол зорилго болон шударга ёсыг тогтооход эрсдэл учруулахуйц бол ид тод байдлын хамрах хүрээнд хязгаарлалт тавьж болохыг хүлээн зөвшөөрдөг⁶⁹. Шүүхээс хуульд заасан нөхцөлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр шүүхийн ил тод байдлын шаардлагыг тодорхойлох⁷⁰ бөгөөд шүүхийн ил тод байдлыг хангах ажиллагаа нь хууль зөрчсөн бодитой үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэхийг зөвшөөрдөг⁷¹. Нөгөөтээгүүр, хуулиар шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын хамрах хүрээнд хязгаарлалт тавих⁷² ба нийтлэг байдлаар төрийн нууц болон хүүхдийн эрхийг хамгаалах үндэслэлээр ил тод байдлыг хязгаарладаг⁷³. Харин манай улсад ЭХХШТХ-ийн 3.2 дугаар зүйлийн 2-т өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын ялагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж, шүүх хуралдааны ил тод байдлыг хангах зарчмыг тусгасан байна.

Шүүхийн шударга ёсны тогтолцоог нийгэмтэй нь уялдуулахын тулд шүүхийн тогтолцоо өөрөө нээлттэй байж, олон нийтэд өөрийн чиг үүрэг зэргийг мэдэгдэж байх явдал чухал юм⁷⁴. Энэ нь шүүхийг хэвлэл мэдээллийн байгууллага болгох тухай хэрэг биш бөгөөд гагцхүү шүүхийн ажиллагаанд ил тод байдлыг хангах асуудал байдаг⁷⁵. Тиймээс шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд хэвлэл, олон нийтийг хүлээн зөвшөөрч шүүх хуралдааныг нээлттэй явуулж, эрүүгийн хэрэгт шүүхэд өгсөн нотлох баримтыг нийтэд мэдээлэх буюу шүүхэд болсон үйл явцын талаар шударга, үнэн зөв тайланг олон нийтэд нийтлэх ёстой гэж үздэг⁷⁶. Мөн хэрэг нь шийдэгдэж байгаа хүмүүс болон шүүх хуралд оролцож байгаа бусад хүмүүсийн нэр олон нийтэд ил тод байх ёстой⁷⁷.

⁶⁹ R (Guardian News and Media Ltd) v City of Westminster Magistrates' Court (Article 19 intervening) [2012] EWCA Civ 420; [2013] QB 618 para 4.

⁷⁰ Ibis.

⁷¹ Clibbery v Allen [2002] EWCA Civ 45 at para 16.

⁷² See Lord Sumption's judgment in *Khuja v Times Newspapers Limited and others* [2017] UKSC 49 para 14.

⁷³ House of Commons Justice Committee, *Open justice: court reporting in the digital age* /Fifth Report of Session 2022-23/ October 2022 p8.

⁷⁴ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

⁷⁵ Ibis.

⁷⁶ Attorney General v Leveller Magazine Ltd [1979] AC 440, 449-450

⁷⁷ R (on the application of C) v Secretary of State for Justice [2016] UKSC 2

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь шүүхийн үйл ажиллагаа, чиг үүргийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх чухал чиг үүргийг хэрэгжүүлдэг⁷⁸. Шүүх болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн хоорондын харилцааг дараах үндэслэлээр дээшлүүлэх нь зүйтэй гэж үздэг. Үүнд: 1) эдгээр байгууллагууд нь хэрэгжүүлдэг чиг үүргээ харилцан ойлгох; 2) олон нийтэд шүүхийн үйл ажиллагааны мөн чанар, цар хүрээ, хязгаарлалтууд, ээдрээ төвөгтэй байдлыг зөв мэдээлэх; 3) тодорхой хэргийн хувьд үйл баримтын зэрэг ташаа мэдээлэл гаргахаас сэргийлэх, залруулах арга хэмжээг авах⁷⁹ шаардлагатай. Шүүхийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд дамжуулах нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн чухал үүрэг юм. Аливаа хэргийг олон нийтийн өмнө хэлэлцэх нь оролцогчдын хувьд хэцүү байх нь эргэлзээгүй бөгөөд эрүүгийн хэргүүд дээр хэргийн нарийн мэдээлэл нь олон нийтийн ёс суртахууныг гутаан доромжлохуйц ёс суртахуунгүй нөхцөлийг үүсгэх сөрөг үр дагавартай⁸⁰. Гэхдээ нээлттэй шүүх хурал нь бүхэлдээ шударга ёсыг хэрэгжүүлэх цэвэр, шударга, үр ашигтай удирдлагын хамгийн сайн баталгаа болохоос гадна шударга ёс нь олон нийтийн итгэл, хүндэтгэлийг олж авах хамгийн сайн хэрэгсэл юм⁸¹. Тиймээс Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид шүүх болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл харилцан ойлголцож, шүүх нь тухайн мэдээллийн хэлбэрийг тодорхойлох, хэвлэл мэдээллийн байгууллага нь хэрэг маргааны мэдээлэх, оролцогчдын нэр эсхүл зургийг гаргах, олны анхаарал татсан нийтийн ашиг сонирхол хөндсөн шүүхийн шийдвэрийг мэдээлэх талаар дүрэм журамтай болохыг дурджээ⁸².

Шүүхийн ил тод байдлын зарчим нь Англо-Саксоны эрх зүйн тогтоолцоотой улс орнуудын шүүхийн тогтолцоотой салшгүй холбоотой бөгөөд уг зарчмын хамрах хүрээг шүүх тодорхойлж, хэрэгжүүлдэг⁸³. Гэсэн хэдий ч шүүхийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зөвхөн шүүхэд хариуцуулах нь өрөөсгөл бөгөөд хууль тогтоогчоос ил тод байдлыг хангахтай холбоотой тодорхой хязгааруудыг хууль тогтоомжоор тодорхойлох нь зайлшгүй юм.

Шүүхийн ил тод байдлыг хангах нь олон нийтийн итгэлийг хамгаалах, шударга ёсыг хангах хамгийн сайн хэрэгсэл⁸⁴ бөгөөд дараах ач

⁷⁸ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

⁷⁹ Ibis.

⁸⁰ Scott & Anor v Scott [1913] UKHL 2 5 May, 1913.

⁸¹ Ibis.

⁸² Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

⁸³ Above p10.

⁸⁴ House of Commons Justice Committee, Open justice: court reporting in the digital age /Fifth

холбогдолтой юм. Үүнд:

- Олон нийтэд шударга ёсыг үнэн зөвөөр хэрэгжүүлж байгааг мэдэх боломж олгох буюу иргэний мэдэх эрх хангагдах;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэлгүй байх эсвэл буруу тайлбар өгөх магадлалыг бууруулах;
- Шүүхийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын зохисгүй үйлдлийг таслан зогсоох⁸⁵;
- Шүүхэд болж буй үйл явдлын талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгснөөр одоо байгаа хууль эрх зүйн орчин, үйл явцтай үр дүнтэйгээр танилцах, үр дүнд олон нийтийн эрх зүйн боловсрол дээшлэх;
- Шүүх хуулийг зөв хэрэглэж байгаа эсэхийг баталгаажуулж, дур зоргоороо шийдвэр гаргахаас сэргийлэх;
- Шударга ёсны хэрэгжилт болон шүүх эрх мэдэлд олон нийтийн итгэл итгэл нэмэгдэнэ⁸⁶.

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэхийн тулд иргэдэд шүүхийн ажиллагаа, тодорхой хэргийн явц зэргийг мэдээлдэг, баримт бичиг гаргаж өгөхөд нь тусалдаг, шүүхийн байрны зохион байгуулалт төвөгтэй тохиолдолд шүүх хуралдааны танхим, холбогдох бусад өрөө тасалгаа руу нь зааж чиглүүлдэг үйлчилгээг бүрдүүлэх нь зүйтэй⁸⁷. Үүнээс гадна, мэдээллийн технологийн шийдэл нь шүүхийн үйл ажиллагааны ил тод сайжруулах хэрэгсэл болох ба шүүх, шүүгчийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөд мэдээлэл өгөх үүргийг гүйцэтгэж байна⁸⁸.

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдал нь шударга ёсыг хэрэгжүүлж буй байгууллагын талаарх мэдээллийг үнэн зөвөөр олон нийтэд хүргэх, шүүхийн үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хяналтыг бий болгох, нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх эерэг үр дүнг бий болгохын зэрэгцээ шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх үр дагаварт хүрч болзошгүй юм. Тиймээс шүүхийн ил тод байдлыг хангах хүрээнд шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, мэдээлэл технологийн шийдлийг ил тод байдлыг хангах хэрэгсэл болгон ашиглах явцад шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэх, түүнийг хөндөхгүй байх ёстой.

Report of Session 2022–23/ October, 2022, p6.

⁸⁵ R v Sarker [2018] 1 WLR 6023, per Lord Burnett CJ, at §29(iv)

⁸⁶ The Legal Education Foundation (committees.parliament.uk/writtenevidence/41210/html/)

⁸⁷ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2005 оны "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж.

⁸⁸ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн 2011 оны "Шударга ёс ба мэдээллийн технологийн тухай" 14-р зөвлөмж.

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нэрийн дор шүүгчид хуваарилагдсан хэрэг маргаантай холбоотой нөлөөлөл, айдас, дарамт, шахалт, заналхийлэл, оролцоог үүсгэх, мөн хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат байлгах⁸⁹ буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах шүүхийн шийдвэр гаргахад нь нөлөөлөх байдлыг хууль тогтоомжоор хязгаарлах, хориглох шаардлага үүсдэг. Тиймээс шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд гарч буй шийдвэрүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байхын зэрэгцээ шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэх, түүнд аливаа хэлбэрээр сөргөөр нөлөөлөхгүй байх шаардлагыг хангах нь зүйтэй.

3.2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ "ИЛ ТОД БАЙДАЛ"-ЫН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт, Шүүхийн тухай хууль, ЭХХШТХ-д "шүүх хуралдааныг нээлттэй явуулах", "шүүхийн шийдвэрийг нийтэд нээлттэй мэдээлэх" зарчмуудыг тусгасан.

- **Шүүх хуралдааныг нээлттэй явуулах:** ЭХХШТХ-ийн 3.2 дугаар зүйлийн 1-д зааснаар төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлгийн нээлттэй явуулна. Хэрэв улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт гаргасан тохиолдолд өсвөр насны яллагдагч, 18 насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно⁹⁰. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгох зохицуулалттай⁹¹.

⁸⁹ Монреалын Шүүгчийн хараат бус байдлын талаарх түгээмэл тунхаглал, 1986.06.10.

⁹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.

⁹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3.



ШИГТГЭЭ 1.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор "Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам"-ыг баталсан. Тус журмаар хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан шүүх хуралдааны танхимд тусгай төхөөрөмжөөр гэрэл зураг авах, бичлэг хийх, олон нийтэд нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр бүрэн эсхүл хэсэгчлэн мэдээлэхийг зөвшөөрөх, татгалзах, түүнийг хязгаарлах, дуусгавар болгох асуудлыг шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Хүсэлтийг шийдвэрлэхдээ шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хэрэг, маргааны талуудын саналыг хүндэтгэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байх, шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны танхимын багтаамжийг харгалзан үздэг⁹².

Шүүхийн хуралдааныг нээлттэй явуулах хүрээнд шүүх хуралдааныг зарыг shuukh.mn вебсайт болон шүүх бүр өөрсдийн албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулж, хаалттайгаас бусад шүүх хуралд хөндлөнгийн ажиглагчаар суух, мөн live.shuukh.mn шүүх хуралдааны цахим системээс шүүх хуралдааны явцын талаарх мэдээллийг авах боломжтой байна.

- Шүүхийн шийдвэрийг нээлттэй байршуулах, тэмдэглэлтэй танилцуулах: Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22 дугаар зүйлийн 22.8-т зааснаар бүх шатны шүүх шийдвэрээ шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим санд байршуулна. Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэж болох талаар зохицуулжээ. Тус зохицуулалтыг хэрэгжилтийг хангах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 343 дугаар тогтоолоор "Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам"-ыг, мөн оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 326 дугаар тогтоолоор "Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэх журам"-ыг тус тус баталсан. Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүгч, шүүх бүрэлдэхүүн дараах тохиолдолд шүүхийн шийдвэрийн тойм болон шүүхийн процессын тоймыг тухай бүр бэлтгэнэ. Үүнд: (1) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор мэдээлэл хүссэн бол; (2) хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд бодит байдлаас зөрүүтэй, төөрөгдүүлсэн зэрэг мэдээлэл гарч, үнэн зөв мэдээллээр хангах шаардлага үүссэн, шүүхэд итгэх олон нийтийн

⁹² Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журмын 3.2.

итгэлд сөрөг нөлөөлөхүйц нөхцөл байдал бий болсон, эсхүл энэ талаар тухайн шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэвэл мэдээлэл хариуцсан нэгжээ мэдэгдсэн бол; (3) тойм гаргасны дараа уг шийдвэр өөрчлөгдсөн, эсхүл хүчингүй болсон.⁹³ Шүүхийн шийдвэрийн эмхэтгэлийн цахим хэвлэлийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон шүүхийн цахим хуудаст, шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байршуулна.

ЭХХШТХ-ийн 11.8 дугаар зүйлийн 1-д зааснаар шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор гаргаж, шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, прокурор, оролцогчид танилцуулна. Мөн зүйлийн 5-д заасны дагуу хэргийн оролцогч нь хүсэлт гаргаж, шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг танилцана.



ШИГТГЭЭ 2.

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 122610 тогтоол, давж заалдах шатны 24367 магадлал, хяналтын шатны 4635 тогтоолыг нийтэд нээлттэй хэлбэрээр байршсан.

Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмын дагуу шүүхийн шийдвэрийн тоймыг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр эрүүгийн хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхийн албан ёсны веб сайтын⁹⁴ "шийдвэрийн тойм" хэсэгт тогтмол байршуулж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс "Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл"-ийг 2015 онд хэвлэж,⁹⁵ өдгөө Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэх журмын дагуу "Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл" мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэлийг⁹⁶ эрхлэн гаргадаг.

Шүүх хуралдааны тэмдэглэл, шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дуу-дүрсний бичлэгийг хэргийн оролцогч бус этгээдэд танилцуулахгүй, олон нийтэд нээлттэй байршуулдаггүй.

⁹³ Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмын 3 дугаар зүйлийн 1.

⁹⁴ Анхан шатны шүүхүүдийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=66&pr=61&tp=list&h=0>

Давж заалдах шатны шүүхүүдийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=67&pr=61&tp=list&h=0>

Хяналт шатны шүүхийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=116&pr=115&tp=list&h=0> Хандалт хийсэн огноо: 2024.02.01

⁹⁵ https://www.judcouncil.mn/site/news_full/13608

⁹⁶ https://www.judcouncil.mn/site/news_full/13608

- **Шүүх хуралдаанд төлөөлөгч оролцуулах:** ЭХХШТХ-ийн 1.32-т зааснаар шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилготой шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэнийг хэлнэ. Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх хуралдаанд иргэдийн төлөөлөгчид оролцуулна. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 8-р сарын 31-ний өдрийн 239 дугаартай тогтоолоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн жишиг тоог баталж, 2023 оны 9-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Энэ журмаар шүүхийн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу нийт хүн амын 1.5 хувьтай тэнцэх хэмжээгээр иргэдийн төлөөлөгчдийн жишиг тоог тогтоожээ.



ШИГТГЭЭ 3.

Улсын хэмжээнд 2022 онд анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн нийт 2127 шүүх хуралдаанд 1924 иргэдийн төлөөлөгч оролцжээ. Иргэдийн төлөөлөгч оролцсон шүүх хуралдааны 998 буюу 46,7 хувь нь эрүүгийн хэргийн шүүхийн шүүх хуралдаан байна⁹⁷. Нийт шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчийн 909 буюу 47,2 хувь нь эрэгтэй, 1062 буюу 55,2 хувь нь эмэгтэй, боловсролын түвшнээр нь авч үзвэл, дээд боловсролтой иргэдийн төлөөлөгч 892 буюу 46,3 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн төлөөлөгч 974 буюу 50,6 хувь, боловсролгүй иргэдийн төлөөлөгч 177 буюу 9,2 хувийг тус тус эзэлжээ⁹⁸.

Сонгогдсон иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалан давхардсан тоогоор 47 шүүх хуралдаан хойшилсон байх бөгөөд 29 буюу 38,5 хувь нь өвчтэй, бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаар шүүх хуралдаан оролцоогүй нь 67 буюу 43.6 хувийг эзэлж⁹⁹ байна. Шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийг оролцуулсан эсэх, оролцуулсан тохиолдолд гаргасан саналыг тусгадаг.

⁹⁷ Шүүхийн Ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан 2022 он", УБ, 2023 он, 297-298-р тал.

⁹⁸ Мөн тэнд.

⁹⁹ Мөн тэнд.

ДӨРӨВ. БУСАД УЛС ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

4.1. ЯПОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ТЕХНОЛОГИ АШИГЛАХАД БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

ЭХХША-ны ил тод байдал нь сүүлийн жилүүдэд тус улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн хэлэлцүүлгийн гол сэдэв болсоор байна. ЭХХША-ны ид тод байдлыг хангахтай холбоотой харилцааг Үндсэн хууль, ЭХХШТХ, Захиргааны байгууллагад хадгалагдаж буй мэдээллийг бусдад гаргаж өгөх харилцааг зохицуулж буй эрх зүйн актаар зохицуулж байна.

Япон Улсын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан этгээд нь шударга шүүхээр шүүн таслах ажиллагааг шуурхай, нээлттэй, явуулах эрхийг баталгаажуулсан. Мөн хуулийн 82 дугаар зүйлд зааснаар шүүх хуралдааныг нээлттэй явуулж, шүүхийн шийдвэрийг нийтэд нээлттэй зарлана. Шүүх бүрэлдэхүүн бүгд санал нэгтэй байгаа тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болох боловч улс төрийн гэмт хэрэг, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг, Үндсэн хуулийн III бүлэгт заасан хүний эрх хөндөгдөж байгаа хэргийн шүүх хуралдааныг шүүх хуралдааныг үргэлж олон нийтэд нээлттэй явуулна.

Тус улсын нээлттэй, ил тод байдлыг хангах зохицуулалт нь "Хаалттайгаас бусад тохиолдолд нээлттэй байх" үзэл санаанд тулгуурлаж, ямар тохиолдолд шүүх хуралдаан хаалттай явах талаар тусгаж, түүнд хамаарахгүй бол нээлттэй явуулах талаар дурджээ. Харин өмнөх бүлэгт судалсан, манай улсын зохицуулалтыг харвал, "нээлттэйгээс бусад нь хаалтай байх" зарчмаар эхний ээлжид нээлттэй байж болох мэдээллийн тодорхойлж, үлдэх мэдээллийг хязгаарлагдмал, хаалттай мэдээлэлд хамруулж байгаа нь олон нийтэд нээлттэй байх мэдээллийн хамрах хүрээ хязгаарлагдмал, эсхүл бүх мэдээллийг хаалттай мэдээлэл болгох асуудлыг үүсгэх нэгэн хүчин зүйл болж байна.

Япон Улсын ЭХХШТХ-ийн 53 дугаар зүйлд зааснаар хэрэг шийдвэрлэгдэж дууссаны дараа шүүх хуралдааны тэмдэглэлийг хэн

ч үзэж болно. Шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэрэг маргааны мэдээлэлд уг зохицуулалт нь хамаарахгүй. Үүнээс гадна, олон нийтэд ил болгохыг хориглосон хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг олон нийтэд мэдээлэхгүй бөгөөд шүүх хуралдааныг тэмдэглэлийг зөвхөн хэргийн оролцогчид эсхүл шүүхээс зөвшөөрөл олгосон этгээдэд танилцаж болохыг хуульчилсан байна. Мөн хуулийн 282 дугаар зүйлд зааснаар нээлттэй шүүх хуралдааныг шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар оролцож, прокурорыг байлцуулан нээнэ.

ЭХХШТХ-ийн 53, 281.4, 256.6-т тус тус заасны дагуу дараах үндэслэлээр хэргийн оролцогчийн хэргийн материалтай танилцах эрхийг хязгаарлаж болно. Үүнд:

- Нотлох баримтыг хадгалахтай холбоотойгоор хэрэг чухал ач холбогдолтой нотлох баримтыг гэмтээх эсхүл устгах эрсдэлтэй гэж үзвэл хандах эрхийг хязгаарлаж болно.
- Нууц мэдээллийг хамгаалахтай холбоотойгоор үндэсний аюулгүй байдалд заналхийлж болзошгүй нууц мэдээллийг задруулахаас сэргийлэх зорилгоор мэдээллийг нууцалж болно.
- Хэргийн оролцогчдын санаа бодолд зүй бусаар нөлөөлөх, яллагдагчийг хохироож болзошгүй мэдээллийг хугацаанаас нь өмнө задруулахаас сэргийлэх зорилгоор нууцалж болно гэх үндэслэл хамаарна.

ЭХХША-ны ил тод байдлыг хангахад мэдээллийн системийн ач холбогдол өндөр болсонтой холбоотойгоор Япон Улсад шүүхийн үйл явцын тодорхой хэсэгт хамаарах цахим системийг нэвтрүүлсэн хэдий ч ил тод байдлыг хангахад чиглэсэн нэгдсэн систем байдаггүй. Тус улсын технологийн интеграцлал нь шүүхийн тогтолцоонд, ялангуяа ЭХХША-ны хүрээнд бусад улс орнуудтай харьцуулахад илүү хязгаарлагдмал юм. Японы шүүх засаглал технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэхдээ уламжлалт байдлаар илүү консерватив байсаар иржээ. Тухайлбал, эрүүгийн процессоос илүү иргэний хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгчээ. Засгийн газрын 2017 оны 06 дугаар сард баталсан "Ирээдүйн хөрөнгө оруулалтын стратеги-2017"-д Японы Засгийн газар шүүх хуралдаанд мэдээллийн технологийн хэрэглээг дэмжих арга хэмжээг шуурхай авч үзэх зорилт тавьсан. Энэ зорилтын хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийн технологийн судалгааны бүлгийг байгуулсан бөгөөд тус судалгааны бүлэг цахимжуулах төслийн үндсэн агуулга болох «3е» (цахим хэрэг бүртгэлт, цахим хэрэг хөтлөлт, цахим шүүх)-г санал

болгосон тайланг эмхэтгэсэн¹⁰⁰. Шүүхийн ажиллагааг цахимжуулах төсөл нь гурван үе шаттайгаар зохион байгуулагдаж байна.

- **1-р үе шат:** Асуудлыг үр дүнтэй зохион байгуулах, төлбөр тооцооны хэлэлцээрийг хянахын тулд веб хурал ашиглах, Microsoft Teams-ийн чатын функцийг хэрэглээнд оруулсан. Microsoft Teams программыг 2020 оны 2-р сараас эхлэн хэрэгжүүлсэн.
- **2-р үе шат:** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулж теле-конференц, веб хурал гэх мэт шүүх хуралдаанд ямар нэгэн этгээд биечлэн оролцохгүй байх боломжийг бүрдүүлсэн.
- **3-р үе шат:** Иргэний шүүхийн цоо шинэ тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэхэд техникийн орчны зохицуулалтыг шаарддаг бөгөөд үүнд цахим мэдүүлэг болон цахим хэргийн бүртгэл зэрэг хамаарч байна¹⁰¹.

ЭХХША-ны хувьд Японы Хууль зүйн яам, бусад захиргааны байгууллагын вебсайтууд болон тухайн мужийн шүүхийн албан ёсны цахим хуудаснууд мэдээлэл, эх сурвалжийг байршуулах зэргээр хязгаарлагдаж байна.

Гэсэн хэдий ч Япон Улс шүүхийн тогтолцоогоо шинэчлэх, тэр дундаа ЭХХША-г үе шаттайгаар шинэчлэхээр ажиллаж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Япон Улс нь шүүхийн системдээ зарим цахим албан бичиг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онлайн журам зэрэг цахим технологийг сүүлийн жилүүдэд эрчимтэй нэвтрүүлэх хандлагатай байна. Ковид-19 цар тахлын үед буюу 2020 онд эрүүгийн болон мөрдөн байцаах ажиллагааг цахимжуулах тухай Засгийн газрын шийдвэрийн дагуу Хууль зүйн яамнаас их дээд сургуулийн багш нар, шүүхийн удирдах албан тушаалтнуудаас бүрдсэн багийг байгуулж, ЭХХША-г цахимжилтын асуудлыг хэлэлцжээ. Япон улсын Хууль зүйн яам ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2024 онд хууль тогтоох байгууллагад өргөн барьсан бөгөөд тус шинэчилсэн найруулгаар цахим баривчлах тушаал, байцаалтын бүртгэлийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна гэж тус яамны ажилтнууд мэдэгдсэн байна. Мөн яллах, батлан даалтад гаргахтай холбоотой бусад мөрдөн байцаалтын ажиллагаа, эрүүгийн

¹⁰⁰ Shusuke Kakiuchi, Minjisaibantetsuduki No ITka -Online Moushitate ■ Soshoukiroku No Denshika [Digitalization of Civil Procedures -Online Filing and Digitization of Case Records], HOURITSU NO HIROBA, Sep 2022, at 13, 13.

¹⁰¹ SAIBAN TETSUDUKITOU NO ITKA KENTOUKAI (IT for Court Proceedings Study Group, Cabinet Secretariat), ITTetsudukitou No ITka Ni Muketa Torimatome [IT Study Group Report for Digitalizing Court Procedures] (Mar 30, 2018), <https://www.kantei.go.jp/jp/singi/keizaisaisei/saiban/pdf/report.pdf>, at 20.

процессыг онлайнаар явуулахыг санал болгосон¹⁰². Үүнд:

- Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдүүлгийг цахимаар авах;
- Шүүх хуралдаанд өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй шүүгдэгчдийг зайнаас оролцох, сэтгэцийн эмч, хэлмэрч нарыг оролцуулахын тулд видео конференц ашиглах;
- Яллагдагчийг яллагдагчаар татсаны дараа хуульчид баримт бичгийг цаасаар хуулбарлахын оронд мөрдөн байцаагчийн цуглуулсан нотлох баримтыг цахим хэлбэрээр харах боломжтой болгох зэрэг багтана.

Япон Улсад ЭХХША-ны шүүхийн өмнөх шатан дахь ажиллагааг үндсэндээ баримтат болон хяналт шалгалт гэж ангилж болох юм. Баримтат гэдэг нь хэргийн оролцогч өөрөө шүүх хуралдаанд нотлох баримт өгөх, хяналт шалгалт нь гэрч, түүнчлэн цагдаа, прокурор, шүүхийн ажилтнуудын авсан мэдүүлэг бүрдүүлнэ¹⁰³. Үүнтэй холбоотойгоор шүүхийн өмнөх шатанд хийгдэж буй ажиллагааг ямар түвшинд цахимжуулахыг тодорхойлох шаардлага үүсжээ.

Мөн ил тод байдлын зохицуулалтынх нь дийлэнх хэсэг нь шүүх ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэж байгаа бөгөөд шүүхийн өмнөх шатанд хэргийн оролцогчид цахим хэлбэрээр өөрийн хэрэгт холбогдох мэдээллийг хүлээн авах, нотлох баримттай танилцах боломжийг хангах нь эрүүгийн процесс ажиллагааны цахим шилжилтийн үйл явц, түүний үр дүнгээс шууд хамаарахаар байна.

4.2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭДЭХ ЭРХИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Холбооны мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (FOIA)-ийг баталж, эрх бүхий төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байхтай холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулж байна¹⁰⁴. Тус хуулиар тус улсын төрийн захиргааны байгууллагын аливаа мэдээлэл, баримт бичгийг нөхцөлгүйгээр хүлээн авах эрхийг баталгаажуулж, зарчим болгон хуульд тусгасан. Энэ хуулиас гадна, төрийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг Захиргааны процессын хууль, Байгаль

¹⁰² An advisory panel on the digitalization of criminal procedures holds a meeting at the Justice Ministry in Tokyo on 4th of December, 2023

¹⁰³ Editorial: Digitizing criminal justice system should ensure civil liberty protections. Komeito. 2022

¹⁰⁴ Peter Schaar "Freedom of information and transparency in Germany", short paper, 2019, p.4-5

орчны мэдээллийн хууль, Хэрэглэгчийн мэдээллийн хууль, Газар зүйн өгөгдөлд хандах эрхийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэний мэдээлэл хүлээн авах эрхийг дараах зорилгоор хязгаарлах шаардлага үүсдэг¹⁰⁵. Үүнд:

1. Хүний хувийн мэдээллийг хамгаалах,
2. Худалдааны болон бизнесийн нууцлалыг хадгалах,
3. Нийтийн болон үндсэн аюулгүй байдлыг хамгаалах,
4. Шүүхийн болон мөрдөн шалгах ажиллагааны үйл явцад хамгаалалт бий болгох зорилго хамаарна.

Холбооны мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар¹⁰⁶ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор дараах мэдээллийг задруулахад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд иргэний мэдээллийг хүлээн авах, олон нийтийн мэдээлэлд хандах эрх хязгаарлагддаг. Үүнд:

- Олон улсын харилцаа;
- Холбооны зэвсэг хүчний бодлого болон аюулгүй байдал;
- Дотоод болон гадаад аюулгүй байдал;
- Хяналт хэрэгжүүлэгч болон зохицуулалтыг байгууллагын үйл ажиллагаа;
- Санхүүгийн хяналтын асуудал;
- Гадаадын хууль бус арилжаа эрхлэгчээс урьдчилан сэргийлэх ажиллагаа;
- Шүүхийн үйл ажиллагааны явцад иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх, эсхүл эрүүгийн, захиргааны, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээлэл орно.

ЭХХША-тай холбоотой мэдээллийг нийтэд ил болгосноор, эсхүл бусдад гаргаж өгснөөр иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхэд болон ЭХХША-нд сөргөөр нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл, төрийн байгууллага нь мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй.



Тус улсын Эрүүгийн процессын хуулийн 32-р зүйлийн 1-д зааснаар эрүүгийн процесс ажиллагааны

баримт бичгийг цахим хэлбэрт хадгалж болох бөгөөд Холбооны Засгийн газар, мужийн захиргаа нь цахим систем дэх мэдээллийг хадгалахтай холбоотойгоор цахим мэдээллийн систем дэх шүүх, прокурорын удирдлагыг зохицуулах, шаардлагатай тохиолдолд системд хадгалж буй баримт бичгийг хэвлэмэл байдлаас хадгалах

¹⁰⁵ Ibis

¹⁰⁶ https://www.gesetze-im-internet.de/englisch_ifg/englisch_ifg.html#p0013 , German Code of Criminal Procedure (Strafprozeßordnung – StPO)

үүргийг тодорхойлох, хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд нээлттэй мэдэгдэл гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг¹⁰⁷. Мөн хуулийн 32а-д заасны дагуу прокурор, шүүхтэй цахимаар харилцах, цахим баримт бичиг гаргаж өгөхөд дараах журмыг баримтална¹⁰⁸. Үүнд:

- Прокурор болон шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах боломжтой байх ёстой. Цахим баримт бичгийг дамжуулах, шилжүүлэхэд тавигдах шаардлагыг Холбооны Засгийн газраас баталж, мөрдүүлэх;
- Баримт бичгийг гарын үсгээр баталгаажуулж байгаа тохиолдолд цахим гарын үсгээр баталгаажуулах;
- Цахим баримт бичгийг дамжуулах аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна (1) Цахим шуудангийн тухай хууль (De-Mail Gesetz)-д заасан de-mail бүртгэлтэй, холбогдсон албан ёсны цахим хаягаар нэвтэрч, цахим баримт бичгийг илгээсэн байх; (2) Өмгөөллийн тухай хуульд зааснаар албан ёсны цахим хаягаар дамжуулан мэдээлэл солилцох аргыг ашигласан байх, эсхүл хуулиар тогтоосон эрх бүхий байгууллага болон шүүхийн байгууллагын цахим шуудангаар дамжуулан харилцах;
- Өгөгдлийг дамжуулахад мэдээлэл илгээгчийг танин баталгаажуулах арга хэмжээг урьдчилан авдаг байх;
- Цахим орчинд хандах эрхийн тухай хууль (Onlinezugangsgesetz)-д заасны журмын дагуу эсхүл эрх бүхий байгууллага, шүүхээс тогтоосон журмын дагуу хувь хүн, хуулийн этгээдийг таньж баталгаажуулж, баримт бичгийг дамжуулах, танилцах боломжоор хангах зэрэг хамаарна.

ХБНГУ-ын эрүүгийн процессын мэдээллийн системд өмгөөлөгч нар хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, түүнд холбогдох баримтыг хавсаргах зэргээр хандах боломжтой байхын зэрэгцээ хүсэлт, гомдлын хууль зүйн үндэслэлийг тодорхой заах агуулгыг хуулиар тодорхойлдог¹⁰⁹. Мөн тус улсад 2017 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цахим орчинд хандах эрхийн тухай хуулийн 1-р зүйлд заасны дагуу мэдээллийн системийн тусламжтайгаар холбооны болон мужийн төрийн байгууллага нь үйл ажиллагаа цахим хэлбэрээр санал болгох шаардлагыг баталж, төрийн байгууллага тус бүрийн систем нь төрийн нэгдсэн мэдээллийн системд холбосон байх үүргийг хүлээлгэсэн байна¹¹⁰. Одоогийн байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид мэдээлэл хүргэх, хүлээн авах боломжийг

¹⁰⁷ https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0015

¹⁰⁸ Ibis.

¹⁰⁹ German Code of Criminal Procedure, Section 32d. https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0015

¹¹⁰ OZG, https://www.gesetze-im-internet.de/ozg/_1.html

бүрдүүлсэн шүүхийн захиргааны <https://egvp.justiz.de/> системийг процессын ажиллагаанд оролцогчид ашиглах боломжийг бүрдүүлжээ.

ХБНГУ-ын www.egvp.justiz.de шүүхийн болон захиргааны цахим шуудангийн платформыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашигладаг. Тус платформ нь төрийн байгууллага, хувийн хэвшил, хувь хүн хоорондоо цахимаар мэдээлэл солилцох боломжтой бөгөөд харилцсан мэдээллийн хүчин төгөлдөр байдлыг хүлээн зөвшөөрдөг.¹¹¹ Төрийн байгууллага бүр өөрийн цахим системтэй байх хэдий ч нэгдмэл мэдээллийн системд холбогдсон байна. ЭХХША-ны явцад хэргийн оролцогч, түүний өмгөөлөгчөөс эрх бүхий байгууллага хүсэлт, гомдол гаргах, түүнд хавсаргасан баримт бичгүүд илгээхэд тус платформыг ашиглах бөгөөд хариуг буцаан цахим хэлбэрээр хүлээн авдаг. Тус системийн онцлог нь хувь хүн, байгууллага нь албан ёсны eVo цахим шуудан хаягийг, харин хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдүүд нь Өмгөөлөгчдийн Холбооноос олгодог тусгай өмгөөлөгчийн (beA) мэйлийг, нотариат бол Холбооны нотариатын танхимаас олгосон тусгай мэйл хаягийг ашиглах боломжийг бий болгож, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд тухайн системийг хувь хүнээс бус мэргэжлийн хүрээнд ашиглах боломж олгодог¹¹². Уг системийг ашиглахтай холбоотой харилцааг ЭХХШТХ, Цахим шуудангийн тухай хууль, Цахим орчинд хандах эрхийн тухай хуулиас гадна Шүүхийн байгууллагатай цахимаар мэдээлэл солилцох тухай хууль, Цахим харилцаа болон цахим шуудангийн техникийн нөхцөл, Шүүхийн тогтолцоонд хэрэг удирдлагын цахим системийг нэвтрүүлэх, цахим мэдээлэл солилцоог хөгжүүлэх тухай хуулиар зохицуулж байна.

Энэхүү платформ нь шүүхүүдийн цахим системтэй холбогдсон ба шүүхийн шийдвэрүүдэд хандах эрхтэйгээр гадна, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг илгээх, хүлээн авах зорилгоор ашиглаж байна.

4.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРЧМЫГ ХУУЛЬД ТУСГАСАН БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

БНСУ-ын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр Үндсэн хууль болон хуулийн дагуу байгуулагдсан шударга шүүхээр шүүлгэх эрхтэй." гэж зохицуулсан. Мөн зүйлийн 3-д хэн боловч шүүх хуралдааныг шуурхай явуулахыг хүсэлтийг гаргах эрхтэй болохыг тусгасан. Шүүх

¹¹¹ https://egvp.justiz.de/beh_allgemeine_info/index.php

¹¹² Ibis.

үйл ажиллагаа ил тод байх буюу олон нийтэд нээлттэй байх зарчмыг Үндсэн хуулийн 109 дугаар зүйлд баталгаажуулжээ. Уг зүйлд шүүх хуралдаан болон шүүхийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй байна. Гагцхүү үндэсний болон олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг алдагдуулах, нийтийн ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц тохиолдолд шүүх хуралдааныг хаалттай явуулж болохоор журамласан байсан.

Тус улсын ЭХХШТХ-иар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримтыг задруулахгүй байх үндэслэлийг тодорхойлсон¹¹³. Уг хуулийн 47 дугаар зүйлд зааснаар нийтийн ашиг сонирхол болон түүнтэй холбогдох шалтгаанаас бусад тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой баримтыг шүүх хуралдаан эхлэхээс өмнө нийтэд задруулахыг хориглосон хэмжээ хэмжээтэй. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоос бусад тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа нууц байх зарчмыг хуульчилсан нь манай улсын зохицуулалттай төсөөтэй гэж дүгнэж болох юм. Гэхдээ цаг хугацааг хуулиар тодорхойлсон байгааг харгалзан үзэх шаардлагатай ба шүүх хуралдаан эхлэхээс өмнө задруулахгүй байх үүргийг хуульчилсан нь шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмыг бэхжүүлэх, түүнийг хөндөхгүй байх хуулийн зорилготой салшгүй холбоотой болов уу.

Улмаар тус улсын ЭХХШТХ-ийн 275 дугаар зүйлд зааснаар шүүх хурлыг шүүгч, прокурор, шүүхийн захиргааны ажилтнуудыг байлцуулах нээлттэй явуулахаар журамлаж, шүүхийн хуралдааны нээлттэй, ил тод байдлыг хуулийн хүрээнд хангасан байна. Мөн тус хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т зааснаар хэргийн оролцогч нь эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, хуулбарлан авах эрхтэй бөгөөд хувь хүн эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны тэмдэглэх танилцах хүсэлтийг прокурорын байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой байна.

Тус улсын ЭХХШТХ-ийн 35, 59.2, 185, 262, 266 дугаар зүйлд тус тус заасны¹¹⁴ дагуу Хэргийн оролцогч, олон нийт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Шүүгдэгч, түүний өмгөөлөгч нь шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэгтээ холбогдох материал, нотлох баримттай танилцаж, түүнийг хуулбарлан авах;

¹¹³ Criminal Procedure Act

¹¹⁴ <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EC%82%AC%EC%86%8C%EC%86%A1%EB%B2%95>
https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535

- Аливаа этгээд эрхээ хамгаалах, эрдэм шинжилгээний судалгаа, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг хуулбарлах хүсэлтийг прокурорт гаргах;
- Прокурор, шүүгдэгч, сэжигтэн, өмгөөлөгч шүүгчийн зөвшөөрлөөр энэ хуулийн 184 дүгээр зүйлд¹¹⁵ заасан захирамжтай холбоотой баримт бичиг, нотлох баримттай танилцаж, хуулбарлан авах;
- Шүүх яллах дүгнэлтийн хуулбарыг шүүгдэгч, түүний өмгөөлөгчид нэн даруй (Энэ нь шүүх хуралдаан болох өдрөөс 5-аас доошгүй өдөр байна) хүргүүлэх;
- Шүүгдэгч, түүний өмгөөлөгч яллах дүгнэлтийн хуулбарыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор яллагдагчаар татагдсан баримтыг хүлээн зөвшөөрсөн эсэх болон шүүх хуралдаанд бэлтгэх журмын талаарх санал дүгнэлтээ шүүхэд гаргах;
- Яллах дүгнэлт гарсны дараа шүүгдэгч, түүний өмгөөлөгч нь хавтаст хэргийн материалын дараах баримтуудтай танилцах, хуулбарлахаар прокурорт бичгээр хүсэлт гаргах эрхтэй:
 - a. Улсын ялагчийн нотлох баримт болгон гаргаж ирэх баримт бичиг (Прокурорын яллах дүгнэлт);
 - b. Улсын ялагч гэрчээр оролцуулахаар төлөвлөж буй хүмүүсийн нэрс, тэдгээр нь хэрэгт оролцсон эсэх, шүүх хуралдаан болохоос өмнөх тэдний мэдүүлэг, түүнийг тодорхойлсон баримт бичиг;
 - c. Шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн хууль, үйл баримтын асуудлаар гаргасан маргаантай холбоотой баримт бичиг (шүүхийн эцэслэн дууссан холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл, яллагдагчаар татаагүй хэргийн бүртгэлийг оролцуулан);
- Прокурор үндэсний аюулгүй байдал, гэрчийг хамгаалах шаардлага, нотлох баримтыг устгаж болзошгүй байдал, мөрдөн байцаалтад саад учруулах тодорхой шалтгаан зэрэг үндэслэлээр уг баримт бичгийг хэргийн оролцогчдод танилцуулах, хуулбарлан авахаас татгалзах, эсхүл бичгээр хүргүүлэх, эсхүл баримтын хамрах хүрээг хязгаарлаж болно.
- Прокурор хэргийн оролцогчдод хэргийн материалтай

¹¹⁵ БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1-т "Прокурор, шүүгдэгч, сэжигтэн, түүний өмгөөлөгч нотлох баримтыг анхан шатны шүүх хурал болохоос өмнө урьдчилан хадгалаагүй бол ашиглахад хүндрэл учруулж болзошгүй шалтгаанаар нотлох баримтыг хавсаргах, магадлуулах, гэрч, шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг арга хэмжээ авах" гэж заасан.

танилцуулахыг зөвшөөрөөгүй, эсхүл хуулбарлахаас татгалзсан, эсхүл бичгээр хүргүүлэх, эсхүл түүнд хязгаарлалт тавих тохиолдолд шалтгааныг нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

- Прокурор шүүгдэгч, түүний өмгөөлөгчид хэргийн материалтай танилцах, хуулбарлан авахыг зөвшөөрөөгүй, эсхүл бичгээр хүргүүлэхээс татгалзсан, эсхүл тэдгээртэй холбоотой хязгаарлалт тогтоосон бол шүүгдэгч, өмгөөлөгч нь түүнтэй танилцах, хуулбарлахыг зөвшөөрөх хүсэлтийг шүүхэд бичгээр гаргаж болно.
- Шүүх хүсэлтийн дагуу яллагдагч, түүний өмгөөлөгчид учирч болох хохирлын хэмжээ, шүүх хурлыг шуурхай явуулах шаардлага зэргийг харгалзан баримт бичигтэй танилцах, хуулбарлах, эсхүл бичгээр хүргүүлэхийг прокурорт даалгаж болно. Энэ тохиолдолд шүүх хэрэгтэй танилцах, хуулбарлах хугацаа, аргыг тогтоож, хэргийн оролцогчид үүрэг оногдуулж болно.

Мөн БНСУ-ын ЭХХШТХ-ийн 59.2-т шүүх хуралдааны тэмдэглэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн үзэх, хуулбарлахыг дараах үндэслэлээр хязгаарлаж болох талаар зохицуулсан. Үүнд:

- Шүүх хуралдааныг хаалттай явуулах үед;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримтыг ил болгосноор үндэсний аюулгүй байдал, ёс суртахуун, нийтийн хэв журам, нийгмийн сайн сайхан байдалд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй үед;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримтыг задруулах нь тухайн хэрэгт холбогдсон хүний нэр төр, хувийн нууц, амь нас, бие махбодын аюулгүй байдал, амар амгалан байдалд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй үед;
- Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримтыг задруулсан нь нотлох баримтыг устгах, хамсаатны харилцаатай этгээд оргон зайлахад дөхөм болох, эсхүл холбогдох хэргийн шүүх хуралдаанд чухал нөлөө үзүүлэх эрсдэлтэй тохиолдолд;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримтыг задруулах нь хэрэгт холбогдогчийн эрүүл мэндийг сайжруулах, нөхөн сэргээхэд ихээхэн хэмжээний саад учруулах боломжтой тохиолдолд;
- Хэргийн оролцогч талуудын арилжааны нууц (Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, худалдааны нууцыг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2-т заасан арилжааны нууцыг дурдаж байна) задруулснаас болж ноцтой зөрчигдөх

эрсдэлтэй тохиолдолд;

- Хэргийн оролцогч шүүх хуралдааны тэмдэглэлийг задруулахыг эс зөвшөөрвөл зэрэг нөхцөл хамаарна.

БНСУ-ын эрүүгийн процессын хууль тогтоомжоор ЭХХША-ны хэргийн оролцогчдын хандах эрхийг хангахын зэрэгцээ хүлээх үүргийг хуульчилсан. Тус улсын ЭХХШТХ-ийн 59.2 дугаар зүйлийн 5-д зааснаар шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцсан, хуулбарласан этгээд нь нийтийн хэв журам, нийтийн ёс суртахууныг алдагдуулах, шүүгдэгчид саад учруулах, хэрэг холбогдсон этгээдийн нэр төрийг гутаан доромжлох, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах аливаа үйлдэл гаргахгүй байх үүрэг хүлээнэ.

БНСУ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим хэрэг бүртгэлийн ECFS систем болон Criminal Justice portal тус тус ашигладаг.

Хэргийн оролцогчдыг мэдэх эрхийг хангах, иргэний хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг бий болгох хүрээнд хэрэг бүртгэлийн цахим мэдээллийн систем ECFS (Electronic Case Filing System)¹¹⁶ ажилладаг. Уг системээр дамжуулан хэргийн оролцогчид, өмгөөлөгчид цахимаар хүсэлт, гомдол, баримт бичиг илгээх, хариуг хүлээн авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримтуудтай танилцах, хэргийн процессыг мэдэх боломжтой байна.



БНСУ-ын Дээд шүүх анх 2001 онд уг системийн загварыг боловсруулж, цахим бүртгэлийн системийг хэрэгжүүлж эхэлснээр "ECFS" системийн суурь тавигджээ. Үүний дараагаар 2008 онд анх иргэний, оюуны өмчийн, гэр бүлийн, захиргааны хэргийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны бүтэн зураглалыг боловсруулсан байна. БНСУ-ын парламентаас 2010 оны 02 дугаар сарын 26-ны өдөр "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичиг бүрдүүлэх тухай хууль" (The Act on the Application of Electronic Documents in the Civil Suits)-ийг баталснаар, цахим иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурийг тавьжээ.¹¹⁷ Улмаар 2010 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр БНСУ-ын оюуны өмчийн маргаан дагнан шийдвэрлэдэг Патентын шүүхээс анх удаа энэхүү системийг ашигласан байна. Энэхүү системээр оюуны өмчийн маргааныг амжилттай шийдвэрлэсний дараагаар 2011 оны 05 дугаар сараас эхлэн иргэний хэргүүд дээр

¹¹⁶ <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>

¹¹⁷ <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>

ECFS программыг туршиж, 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүх төрлийн иргэний хэргүүдийг уг системд нэвтрүүлсэн байна. Цаашид эрүүгийн хэргээс бусад бүх төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэхүү системээр дамжуулан явуулах боломжтой болгох тал дээр ажиллаж байгаа ажээ.

ECFS системээр дамжуулан хэрэг үүсгэхээс эхлээд шүүх хуралдаан хүртэлх бүхий л шатанд хэргийн оролцогчид цахимаар оролцох, үйл явцтай танилцах, хяналт хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, уг системээр дамжуулан хэргийн оролцогч нь гомдол, нэхэмжлэл гаргах, нотлох баримт гаргаж өгөх, эсрэг талын гаргаж буй баримтуудтай танилцах зэрэг олон төрлийн баримт бичгийг байршуулах болон тэдгээртэй танилцах эрхтэй. Улмаар хэргийн оролцогч шүүх болон эсрэг талын хүсэлт, аливаа эрх зүйн баримт бичигтэй цаг алдалгүй танилцан хариу өгч, хуулбарлан авдгаараа давуу талтай. Цаашлаад шүүгч болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар уг системээр дамжуулан хэргийн үйл явцыг хянах, шалгах, баталгаажуулах зэрэг үйлдэл хийж боломжтой. Шүүх хуралдааны өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа энэхүү системээр дамжигдан хийгдсэний дараа шүүх хуралдаан шүүх хурлын танхимд болно. Одоогийн байдлаар энэхүү системийн үйлчилгээ нь олон нийтэд бус зөвхөн хэргийн оролцогчдод нээлттэй байгаа бөгөөд цаашид хэргийн оролцогчдын нэрийн нууцлалтайгаар цахим хаягт олон нийт хайлт хийх боломжтой болгох арга замыг эрэлхийлж байна.

Criminal Justice Portal буюу Эрүүгийн шүүхийн платформ¹¹⁸ нь цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллагын нэгтгэсэн мэдээллийн систем юм. Эрх бүхий байгууллагууд дотоодод мэдээлэл солилцох, гаднаас хэргийн оролцогч, иргэд мэдээлэл авах боломжтой байхаар зохион байгуулагдсан систем гэж үздэг.



Энэ систем нь дээрх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системтэй харьцуулахад хэргийн оролцогчийн хувьд хязгаарлагдмал боломжуудтай. Эрх бүхий байгууллагын системээр дамжуулан хэргийн оролцогчдоос хэргийн явцтай танилцах хүсэлтийг цахимаар гаргаж, хариуг буцаан лавлагаа хэлбэрээр авах, ЭХХША-тай холбоотой

¹¹⁸ <https://fgn.kics.go.kr/en/jsp/cjp/criminalJustice.jsp>


хүсэлт, гомдлыг, түүнд хавсаргасан бичиг баримтын хамт цахимаар илгээх, хүсэлтээсээ татгалзах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг ил болгох хүсэлт гаргах зэрэг боломжийг олгож байна. Үүнээс гадна, олон нийтээс гэмт хэргийн статистик тайлан мэдээлэлтэй танилцаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хэлэлцүүлэгт оролцож, үзэл бодлоо илэрхийлэх боломжтой. Тус системийн тусламжтайгаар согтуугаар эсхүл эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсонтой холбоотой хэргийн бүртгэлийг бүрэн цахим хэлбэрээр явуулж байна. Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж, цахим хэргийг прокурор руу илгээж, прокуророор цахимаар тогтоол гаргаж, шүүхэд очсоноор шүүхийн торгууль оногдуулсан шийдвэрийг гаргана. Улмаар цахимаар гарсан шийдвэртэй танилцах холбоосыг хэргийн оролцогчийн утсанд илгээж, мөн шуудангаар шийдвэрийг хувийг хүргүүлдэг.

Criminal Justice Portal системээр дамжуулан мөрдөн байцаах, яллах, шүүн таслах, гүйцэтгэх ажиллагаанд энэхүү стандарт мэдээллийн системийг ашиглахаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээлэл, бусад баримт бичгийг хоорондоо солилцдог. Мөн иргэн, хэргийн оролцогчийн хувьд өөрийн бүртгэлээр нэвтрэн орж хүссэн цагтаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцтай цахимаар танилцаж, төрийн үйлчилгээг цахимаар авах боломжтой. Тус системд дээрх үндсэн 4 байгууллагаас цахимаар болон бичгээр авах боломжтой үйлчилгээг жагсааж, хүсэлт шийдвэрлэх хугацаа, хариуцах этгээд зэргийг маш тодорхой, хэрэглэхэд хялбараар хөгжүүлсэн. Тухайлбал:


№	Үйлчилгээний нэр	Эрх бүхий байгууллага	Хэлбэр	Шийдвэрлэх хугацаа
1	Хэргийн тэмдэглэлтэй (case records) танилцах, хуулбарлан авах хүсэлт	Прокурор	цахимаар	1 өдөр
2	Сэжигтний нөхөн төлбөр авах өргөдөл	Прокурор	бичгээр	10 өдөр
3	Бичмэл өргөдөл (written plea)	Шүүх	цахимаар	нэн даруй

Энэ мэтчилэн тус системд дийлэнх нь прокурорын байгууллагад, зарим нь хууль зүйн яаманд, цөөн тохиолдолд шүүхэд хүсэлт гаргах, үйлчилгээ авчээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэнд үзүүлж буй үйлчилгээний эзлэх хувь



Хүсэлт шийдвэрлэх хэлбэр



Иргэн, хэргийн оролцогчдоос гаргасан гомдол, хүсэлтийг хариуг цахимаар, бичгээр хариу хүргүүлэх хуулийн зохицуулалт тус системээр дамжиж хэрэгжиж байна.

4.4. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ НЭВТРҮҮЛСЭН САЙН ТУРШЛАГА (АНУ, АВСТРИ УЛС)

Япон Улсын Окинава хотод 2000 онд зохион байгуулагдсан Их Найман гүрний ээлжит уулзалтаар Дэлхийн мэдээлэлжсэн нийгэм тунхаг (Okinawa Charter on Global Information Society)-г баталсан цагаас эхлэн улс орон бүр мэдээлэл технологийн зохистой хэрэглээг хүн бүрд эзэмшүүлэх, төрийн болон хувийн хэвшлийг үйл ажиллагааг цахимжуулах, хууль тогтоомжийг цахим орчинд хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн. Угтаа мэдээлэл технологийн нөлөөлөл цаг тутамд нэмэгдэж буйтай холбоотойгоор хүн хоорондоо аливаа техник хэрэгсэл, мэдээллийн системээр дамжиж харилцаж байх тул аливаа баталсан хуулийн хэрэгжилтийг хангахад мэдээллийн системийг ашиглах боломж нөхцөлийг тодорхойлж, түүгээр дамжуулж хуулийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж байна.

Өмнө нь ЭХХША-ны ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхэд

тухайн төрийн байгууллагад ирсэн гомдол, мэдээлэлд албан бичгээр хариу өгч буй байдал, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрэг хянан шийдвэрлэх талаар үнэн зөв мэдээлэл хүргэж буй байдал, цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад нэвтэрч, мэдээлэл авах нөхцөлийг хангасан байдал, шүүх хуралдаанд хөндлөнгийн оролцогчид оролцох боломжийг хангасан байдал зэрэг тухай байгууллагад очиж, мэдээлэл хүсэх, хүлээн авах, үйл ажиллагаанд оролцох зэрэг ойлголтуудыг чухалчлан авч үзэх хандлага байсан. Үүнээс улбаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангахад хуулийн зохицуулалт, түүнд батлагдсан дүрэм журмуудаар зохицуулж, бодит байдалд түүний хэрэгжилтийг хангаж байсан.

Харин өнөө цагт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангахад зөвхөн хууль батлах, түүний хэрэгжилтийг бодит орчноор хязгаарлах замаар төрийн байгууллагад ирж мэдээлэл авах, эрх бүхий албан тушаалтнаас хариуг хэвлэмэл байдлаар өгөх, шүүх дээр биечлэн очиж шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломжийг хангах нь хангалтгүй байхын зэрэгцээ ач холбогдол бага байгаа нь хүн амын мэдээлэл технологийн хэрэглээ ихэссэнтэй салшгүй холбоотой юм.

Тиймээс хуулиар баталгаажуулсан ЭХХША-ны ил тод байдлыг хангахад хүн амын хэрэглээ, мэдээлэлжсэн нийгмийн хөгжилд нийцүүлэн эрүүгийн хэргийн цахим мэдээллийн системийг ашиглаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, олон нийтээс тухай бүр мэдээлэл авах, мэдээлэл хүлээн авах эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлжээ.

I. АНУ-ын Аризона мужийн (Arizona Judicial branch/e-access) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангасан олон нийтэд нээлттэй систем



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал нь хэргийн оролцогчид хэргийн холбогдох баримт, мэдээлэл хандах нөхцөлийг

бүрдүүлсэн систем байхаас гадна олон нийтийн хяналтыг бэхжүүлэх хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүхийн шийдвэр, мэдэгдэл, захирамжуудтай танилцах боломжийг бий болгосон.

eAccess системийн тусламжтайгаар хүн бүр нь *Arizona Judicial Branch* платформын *Public Access to Court Information* хайлтын системээр дамжуулан 24/7 цагийн горимоор хэргийн оролцогчдод хамааралтай шүүхээс гаргасан шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүхээс авч буй албадлагын арга хэмжээ авах захирамж, тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлтэй цахимаар танилцах, pdf өргөтгөлөөр татан авах боломжтой байна¹¹⁹.

Одоогоор¹²⁰ eAccess системд 2010 оны 7 дугаар сарын өдрөөс хойш иргэний болон эрүүгийн хэргийн бүртгэлийн мэдээллийг байршуулсан бөгөөд эрх бүхий байгууллагаас хандалтын хязгаарласнаас бусад бүх хэрэг бүртгэлтийн мэдээлэлтэй олон нийт танилцах эрхтэй байна.

Хэрэгт хамаарах дараах мэдээлэлтэй танилцах боломжтой. Үүнд:

Case Number	Description	Type
1210002	APPOINTMENT	01
3200002	APPLICANT DEFAULT AND ENTRY OF DEFAULT	01
3200002	APPLICATION ENTRY OF DEFAULT	01
3400002	APPLICANT DEFAULT AND ENTRY OF DEFAULT	01
3400002	APPLICATION ENTRY OF DEFAULT	01
2200002	SERVICE CERTIFIC	01
1210002	CERTIFICATE OF SERVICE	01
1210002	ORDER VACATING	01
1210002	NOTICE VACATE	01
1210002	COMPLAINT AMENDED COMPLAINT	01
1210002	ABSTRACTION CERTIFICATE OF COMPULSORY ABSTRACTION - IS NOT	01
1210002	ORDER PROPOSED ORDER	01
1140002	NOTICE OF FILING	01
1030002	APPLICATION ENTRY OF DEFAULT	01

- Хэргийн оролцогч талуудын нэр, хэргийн дугаар,
- Шүүхийн нэр, хэрэг үүсгэсэн огноо, хэргийн процесс ямар дарааллаар хэрхэн явагдсан цаг хугацаа,
- Процессын явцад ямар ямар ажиллагаа хийгдсэн дараалал зэрэг хамаарна.

Дээр дурдсан хэргийн материал, бичиг баримтуудтай дэлгэрэнгүй танилцахын тулд дараах ажиллагааг

хийнэ. Үүнд:

- eAccess portal системд бүртгүүлж, "худалдан авалт" хийснээр танилцах боломжтой байна.
- Баримт бичиг татаж авах тохиолдолд 80–10000\$-ийн Subscription төлснөөр бүртгэлтэй ямар ч этгээд хэргийн дугаар, хэргийн оролцогчийн нэр, шүүхийн нэр, үйл явдлын агуулгаар шүүлт хийн мэдээлэл авах боломжтой байна.
- Цахим системийн мэдээллийг 2 жил тутам шинэчилдэг.

¹¹⁹ [https://apps.supremecourt.az.gov/publicaccess/\(X\(1\)S\(oe2qmyejx5oo0riiwxheh55\)\)/case-lookup.aspx](https://apps.supremecourt.az.gov/publicaccess/(X(1)S(oe2qmyejx5oo0riiwxheh55))/case-lookup.aspx)

¹²⁰ Хандалт хийсэн огноо: 2024.06.17

Олон нийтэд үүсэж буй боломж	Хандах боломжгүй мэдээллийн агуулга
<ul style="list-style-type: none">- Аризонагийн Дээд шүүхийн 2010 оны 07 сарын 01-ний өдрөөс хойш үүссэн иргэний болон эрүүгийн хэргийн мэдээлэл- Худалдан авсан баримт бичгийг харах, татаж авах боломжтой 24 цагийн үйл ажиллагаа- Баримт бичгийг цахимаар баталгаажуулах боломж	<ul style="list-style-type: none">- Нууцад хамаарах зарим мэдээлэл (жишээ нь: хамгаалалтын баримт бичиг, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, яллах баримт бичиг (charging documents), баталгааны баримт бичиг)

Энэхүү систем нь хэргийн оролцогчдын хандах эрхийг хангахаас гадна нээлттэй мэдээллийн санг бүрэн хөгжүүлж, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангаж, хөндлөнгийн хяналтыг технологийн шийдлийн тусламжтайгаар бий болгожээ.

II. Австри Улсын Die Österreichische Justiz шүүхийн цахим систем



DIE ÖSTERREICHISCHE JUSTIZ
justizonline.gv.at

Justiz цахим систем¹²¹ нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон ЭХХША-ны хувьд ялгаатай байдлаар системд бүртгэл бүхий иргэн, оролцогчид баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлжээ. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц, шүүхээс баримт бичигтэй танилцах боломжтой. Харин ЭХХША-тай холбоотой баримт бичиг, түүний үйл явцтай танилцах гэж буй тохиолдолд эрх бүхий байгууллагад урьдчилж хүсэлт явуулахаар зохион байгуулагдсан. Шийдвэр гаргах байгууллагаас холбогдох хүсэлтийг шийдвэрлэсний дараа хэргийн үйл явцтай болон холбогдох баримт бичгүүдтэй танилцах, тухайн баримтыг татаж авах боломжтой.

Мөн энэхүү цахим системээр дамжуулан хэргийн оролцогчид шүүх, прокурорын байгууллага болон цагдаа гэх мэт эрх бүхий байгууллагаас гаргасан заасан цаг хугацаанд хүрэлцэн ирэх дуудах бичгийг өөрийн биеэр ирж, хүлээн авах шаардлагагүйгээр танилцах боломжтой. Цахим системээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах мэдээллийг харах боломжтой. Үүнд:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хадгалагдсан үйл явцыг хугацааны дарааллаар;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүхээс гарсан баримт бичгүүд;

¹²¹ <https://justizonline.gv.at/jop/web/content/akteneinsicht>

-
- Хэрэв шүүх хурал товлогдсон тохиолдолд шүүх хурал болох огноо болон шүүх хурал болох шүүхийн мэдээлэл;
 - Хэргийн оролцогчийн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар эрх, үүрэгтэй оролцох талаарх мэдээлэл зэрэг орно.

Тус шүүхийн цахим систем иргэдэд ээлтэй (citizen-friendly) төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагааг цаасгүйгээр шуурхай явуулах боломжийг олгодог онцлогтой. Энэ системээр дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах цахим үйлчилгээг хэргийн оролцогч, иргэд авах боломжтой. Үүнд:

1. My Procedures: Хэргийн оролцогч нь өөрийн бүртгэлээр системд нэвтэрч, шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн мэдээлэл, процесстой танилцах боломжтой.
2. Шүүх, прокурорын байгууллагаас ихэвчлэн шаарддаг хүсэлт, өргөдөл, баримтыг бичгийн загварыг нээлттэй татан авах боломжтой.
3. Шуудангийн үйлчилгээ: Шүүхээс цахимаар ирүүлсэн хариу албан бичгүүдтэй танилцах, хариу илгээх, баримт бичиг солилцоно.
4. Газрын бүртгэлийн лавлагаа: Хаягийн хайлт, газрын бүртгэлийн хуулбар, баримт бичгүүдийг шууд авах боломжтой.
5. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл: Компаниудын бүртгэл, баримт бичгийн хуулбарыг шүүхээс авах боломжтой.
6. Шүүхийн хураамж цахимаар тооцох боломжтой.

ЭХХША-нд нэвтрүүлсэн дээрх мэдээллийн системүүд (а) мэдээллийн технологийн шийдлийн давуу талтай холбоотойгоор, (б) мэдээллийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ач холбогдлыг бий болгожээ. Үүнд:

А. Мэдээлэл технологийн шийдлийн давуу тал:

- i. Хэргийн оролцогчдод ээлтэй, ЭХХША-нд оролцоход хялбар тогтолцоог үүсгэж байна.

Мэдээллийн системийн функцийн тусламжтайгаар хүсэлт гаргах, гомдол гаргах, түүнтэй холбоотой хариуг хүлээн авах хялбар горим бий болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, процесс хэрхэн явагдаж байгаа, цаашид хэрхэн явагдах талаарх бүрэн мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн нь нэг талаас систем нь ЭХХША-ны хөтөч, нөгөө талаас интернэтээр дамжуулан хүссэн цагт 24/7 горимоор мэдээлэл хандах боломжийг үүсгэжээ.

- ii. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацаа, зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлсэн.

Цахим хэрэг бүртгэлийн систем нь хэргийн оролцогчдоос хүсэлт, гомдол гаргах, хариуг хүлээн авах, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэртэй танилцах, зарлан дуудах хуудсыг хүргэж өгөх, хэргийн баримтууд дээр гарын үсэг зурах, мөрдөгч, прокурор, шүүхийн гаргасан шийдвэрүүдтэй танилцах, шүүх хуралдаанд оролцох, шинжээчийн дүгнэлттэй танилцах, хэргийн материалтай танилцах, шүүхийн шийдвэр гардан авах, шүүхийн тэмдэглэлтэй танилцах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудтай холбоотойгоор цагдаагийн байгууллага, прокурорын байгууллага, шүүхийн байгууллагад заавал биечлэн очих, төрийн байгууллагууд бичиг хэрэг хүргэгчийн тусламжтайгаар хоорондоо баримт бичгүүдээ солилцох явцад гарч буй цаг хугацааны болон эдийн засгийн зардлыг үгүй болгох шийдэл юм. Систем нь цаасны хэрэглээг бууруулж, байгаль орчинд ээлтэй нөхцөл давхар хангаж байна.

iii. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах замаар баримт бичгийн үнэн зөв байдлыг баталгаажуулсан.

Хэргийн оролцогч, хэрэгжүүлэгч нарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны системд нэвтрэх тусгай эрхийг олгож, түүгээр дамжуулан түүнийг таньж баталгаажуулах замаар илгээж буй баримт бичгийн бүрэн байдлыг хангаж, системд техникийн тусгай нөхцөл тавьж, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системд мэдээллийг хадгалж, баримт бичгийн үнэн зөв байдлыг хадгалах арга хэмжээг авч байна.

Б. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд:

i. Мэдээллийн системийн тусламжтайгаар бодит цагийн горимоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих боломж бүрдсэн.

Эрх бүхий байгууллагад гаргасан хүсэлт, гомдол нь хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдэж буй эсэхэд хяналтыг шууд хэрэгжүүлэх боломжтой бөгөөд мэдээллийн системийн мета датаг ашиглан илгээсэн хугацаа, илгээгчийн мэдээллийг давхар баталгаажуулах боломжтой. Үүний үр дүнд цахим баримт бичгийн эргэлт нэмэгдэж, мэдээллийн системээр дамжуулан хүсэлт, гомдлын хариуг цаг тухайд нь илгээх, эсхүл шинжээчийн дүгнэлт, прокурорын тогтоол, шүүхийн шийдвэр, захирамжийг бодит цагийн горимоор танилцуулах, эсхүл гардуулах боломжийг үүсгэж, цаашид хэргийн оролцогчоос гомдол гаргах хугацааг бүрэн эдлэх боломжийг бүрдүүлжээ.

ii. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрийн агуулга, хууль зүйн үндэслэлд олон нийтийн

хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл бий болсон.

Мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарахгүй, хэргийн оролцогчийн зөвшөөрсөн эсхүлтүүний эрхийг хязгаарласан прокурорын тогтоол, шүүхийн шийдвэртэй танилцах боломж бүрдсэнээр эрх бүхий байгууллагын шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй эсэх, тухайн тохиолдолд нийцэж буй эсэх агуулгын хяналтыг хэрэгжүүлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, цаашид хүний эрхийн зөрчлийг үүсгэх хууль тогтоомжийг өөрчлөх санал, санаачилгыг гаргах үндэс нь болно.

- iii. Эрх бүхий албан тушаалтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлсэн.

ЭХХША-ны тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэргийн оролцогчдод хандах эрхтэйгээр системд байршуулж эхэлснээр, эсхүл цахим хэлбэрээр хариу өгч эхэлснээр тухайн шийдвэрийн хууль зүйн үндэслэл сайжрах, хууль тогтоомжид заасан хугацаанд хариуг өгөх, холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэх, хариуцлагатай байх шаардлага үүсэж байна.

- iv. ЭХХША-ны талаарх оролцогчдын мэдлэгийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад зарцуулагддаг зардал буурна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл, нийтлэл гаргах, аян өрнүүлэх зэргээр шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мөрдөн шалгах ажиллагаан дахь хэргийн оролцогчийн эрхийг таниулах зэрэг арга хэмжээг тогтмол жил зохион байгуулах бус мэдээллийн системээр дамжуулан мэдээллийг хүргэх, сурталчлах, эрх зүйн боловсрол зориулсан зөвлөгөө мэдээлэл байршуулах, хууль тогтоомж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үзэл бодлоо илэрхийлэх цахим хэлэлцүүлэх зохион байгуулах зэргээр шийдвэрлэх боломжтой.

Улс орнуудын цахим мэдээллийн систем, тэдгээрийн онцлог, ач холбогдлоос үзвэл, мэдээллийн технологийн давуу байдлыг ЭХХША-нд ашиглах нь зайлшгүй бөгөөд хэрэгцээтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Улмаар тухайн улсын онцлогт нийцүүлэн, эсхүл техникийн боломж бололцоо, төсөв, өмнөх туршлагад тулгуурлан ЭХХША-ны цахим мэдээллийн системийг нэвтрүүлэх төлөвлөгөө гаргах нь зүйтэй юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

ДҮГНЭЛТ 1. ЭХХША-ны ил тод байдлыг хангах асуудал нь эрүүгийн процессын онцлогт тулгуурлан (1) шүүхээс өмнөх шатанд буюу мөрдөн шалгах ажиллагаанд, (2) шүүхийн шатанд буюу шүүх хуралдаанд тус тус нээлттэй, ил тод байдлыг хангаж буй эсэхийг хамаарч байна. Монгол Улсад шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн хуралдааны нээлттэй ил тод байдлыг хангахад хууль, журам, бодлогууд батлагдсан хэдий ч шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах зохицуулалт дутмаг байна.

Нөгөөтээгүүр, мэдээлэл хүлээн авах эрх бүхий субъектэд үндэслэн олон нийтийн мэдэх эрхийг хангасан эсэх, хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгчийн, өмгөөлөгчийн мэдээлэл авах хуульд заасан эрхийг хангаж буй эсэхийг судалж үзэхэд, шүүхийн өмнөх шатан дахь харилцааг зохицуулж буй ЭХХШТХ, Прокурорын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулиудад хэргийн оролцогчийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан, олон нийтэд нээлттэй байх мэдээллийн талаарх зохицуулалт байхгүй. Хэргийн оролцогч мэдээлэл авах хүсэлтийг прокурорт гаргаж, шийдвэрлүүлэхээр зохицуулсан нь прокурорын дүгнэлт, шийдвэрийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангагдах эсэх нь тодорхойлогдож байна.

Улмаар прокурорын зөвшөөрлөөр хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахаар авч буй арга хэмжээний хууль ёсны байдал, зүй ёсны процедур шаардлагыг хангаж буй эсэх, авч буй албадлагын болон таслан сэргийлэх арга хэмжээ нь зорилгодоо тохирсон эсэх зэрэгт олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй.

САНАЛ 1. ЭХХША-ны ил тод байдлыг хангаж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангахуйц зохицуулалтыг ЭХХШТХ-д тусгах.

ЭХХША нь захиргааны болон иргэний процесс ажиллагаатай харьцуулахад, хүний хувийн мэдээлэл, эмзэг мэдээлэлтэй салшгүй холбоотой байхын зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааны нууцыг чанд хадгалах зарчмыг шүүхийн өмнөх дагаж мөрддөг. Тиймээс шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгахад дараах хүчин зүйлсийг анхаарах шаардлагатай.

Нийтэд ил болгох боломжтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл нь хэргийн оролцогчийн эрх, хууль ёсны ашиг

сонирхлыг зөрчөөгүй, түүнд хохирол учруулахуйц байх ёсгүй, мөн уг мэдээлэл нь мөрдөн байцаалтын нууцад хамаарах ёсгүй. ЭХХШТХ-д мөрдөн байцаалтын нууцад юуг хамаарах талаар нарийвчлан зохицуулж, прокуророос ямар тохиолдолд мэдээлэл гаргуулах хүсэлтийг хангахгүй үндэслэлийг хуульд тодорхой тусгаж өгснөөр субъектив байр сууринаас зөвшөөрөл олгохгүй байх тохиолдлууд буурна.

ДҮГНЭЛТ 2. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ЭХХША-ны мэдээллийг ил тод болгоход прокурорын зөвшөөрөл шаардлагатай. Прокурор зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн мэдээллийг ил тод болгохгүй, улмаар олон нийтийн хяналт хэрэгжих боломжгүй байна.

САНАЛ 2. ЭХХША-ны ил тод байдлыг нь олон нийтийн хяналтыг бие болгох замаар эрх бүхий албан тушаалтны мэргэжлийн хариуцлага өндөрсгөх, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс сэргийлдэг. Тиймээс прокурор, шүүхээс хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан шийдвэр гаргасан тохиолдолд олон нийтэд нээлттэй байршуулах, эсхүл хэргийн оролцогчийн хүсэлтээр ил болгох нь тухайн шийдвэрийн үндэслэлтэй байдал, зайлшгүй байдалд хөндлөнгийн хяналт хийх боломж бүрдэж, цаашлаад шийдвэрийн үндэслэлтэй байдал нэмэгдэнэ. Тиймээс тухайн хэргийн оролцогчийн эрхийг хязгаарласан шийдвэрийг түүний хүсэлтээр ил болгохоор зохицуулах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ 3. ЭХХШТХ-ийн 29.3.5-д заасан прокурорын зөвшөөрлөөр нийтэд мэдээлсэн буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын баримтыг ил болгосон талаарх мэдээлэл, тайлан <https://police.gov.mn/p/3889> , <https://prokuror.mn/> олдоогүй.

САНАЛ 3. ЭХХША-ны явцад ил тод болгосон баримтуудтай холбоотой тайлан, мэдээг тогтмол байршуулснаар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх тул мэдээллийн хүртээмжтэй байдлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас хангах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ 4. Цагдаагийн үйл ажиллагааны журмууд болон Улсын Ерөнхий прокуророос баталсан эрх зүйн актууд олон нийтэд нээлттэй бус бөгөөд эдгээрээс гадагш чиглэсэн эрх зүйн актыг хүний эрхийг хязгаарлах харилцаанд ашиглаж байна.

САНАЛ 4. Эдгээр эрх зүйн актууд нь зөвхөн байгууллагын

дотоод зохион байгуулалтыг зохицуулсан хэм хэмжээ биш учраас байгууллагын дотоод бүтэц зохион байгуулалтад хамаарахгүй, бусад эрх зүйн актуудыг нээлттэй хандах эрхтэйгээр байршуулах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ 5. Япон, ХБНГУ, Австри Улс, БНСУ-д эрүүгийн цахим мэдээллийн системийг хөгжүүлж буй байдлыг харахад дараах шат дарааллаар хөгжүүлж байна. Үүнд: (1) шүүх, прокурор, цагдаагийн байгууллага хооронд болон хэргийн оролцогч нар эрх бүхий байгууллагатай баримт бичиг, мэдээлэл солилцох цахим шуудангийн системийг үүсгэх, (2) хэргийн оролцогч, төлөөлөгч, өмгөөлөгчийн нарын нэвтрэх эрхийн тухайлан олгох, аюулгүй байдлын хангах, (3) мэдээлэл солилцох боломжийг олгох, цахим хэлбэрээр тодорхой төрлийн ЭХХША-г явуулж, туршилт хийж, баталгаажуулах, (4) эрүүгийн хэргийн системийг үүсгэж, түүн нэвтэрч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээллийг авах, хүсэлт, гомдол гаргах, бодит цагийн горимоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны материалуудтай танилцах.

САНАЛ 5. Монгол Улсын эрүүгийн хэргийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем *e-justice.mn* дараах байдлаар хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх замаар хэргийн оролцогчдын мэдэх эрхийг хангах нь зүйтэй. Тухайн системд хандах эрх бүхий этгээдийн бүрэн тодорхойлж, Монгол Улсын иргэн бүрд олгосон *e-mongolia* албан ёсны мэйл хаягаар хувь хүнийг цахимаар хүсэлт, гомдол илгээх боломжоор хангаж, хариуг мөн албан ёсны мэйл хаягтаа хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх. Дараагийн ээлжид, шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нар өөрийн харьяа байгууллагаас олгосон тусгай мэйлээр системд нэвтэрч, цахим мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлэх. Үүнээс гадна, олон нийтээс ЭХХША-ны мэдээлэл авах цэс үүсгэх: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм, прокурорын залруулга, прокурорын зөвшөөрлөөр ил болгосон баримтууд, цагдаагийн үйл ажиллагаанд болон прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөж гадагш чиглэсэн актуудыг тус тус байршуулах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ 6. АНУ-ын Аризоны мужийн шүүхийн платформын *e-Access* систем нь эрүүгийн хэргийн мэдээлэл, шүүхээс гарсан шийдвэртэй бүрэн танилцах боломжийг олон нийтэд олгосон нь ЭХХША-ны ил тод байдлыг хангасан сайн жишээ болж байна.

САНАЛ 6. Эрүүгийн хэргийн мэдээллийн системд эрх бүхий

байгууллагууд болон оролцогч нарын үйл ажиллагааг нарийн уялдуулан шаардлага гарах бөгөөд үүнийг аль нэг байгууллага дангаар шийдвэрлэх төвөгтэй бэрхшээлтэй байхын зэрэгцээ мэдээллийн аюулгүй байдал, техникийн шаардлагыг хангасан системийг нэвтрүүлэх төсөв, ажиллах хүч, хөгжүүлэх багийн хэрэгцээ шаардлага гарна. Манай улсын одоо цагт хэрэглээнд нэвтэрсэн, гадагш чиглэсэн систем байхгүй тул шууд олон нийтийн хандалтыг хүлээн зөвшөөрсөн систем хөгжүүлэх нь төвөгтэй байж болох юм. Гэвч тодорхой төрлийн гэмт хэрэг дээр тулгуурлан олон нийтэд чиглэсэн эрүүгийн хэргийн цахим системийг хөгжүүлэх нь зайлшгүй юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966
- Шүүхийн тухай хууль, 2021
- Прокурорын тухай хууль, 2017
- Цагдаагийн албаны тухай хууль, 2017
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 2021
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016
- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 11-р сарын 18-ны өдрийн 326 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэх журам.
- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 12-р сарын 15-ны өдрийн 343-р тогтоолоор баталсан Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам.

Монгол хэл дээрх эх сурвалж:

- Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл, "Шударга ёс ба нийгмийн асуудалд Европын асуудалд Европын зөвлөлийн сайд нарын хорооны анхаарлыг хандуулах тухай" 7 дугаар зөвлөмж, 2005
- Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл, "Шударга ёс ба мэдээллийн технологийн тухай" 14-р зөвлөмж, 2011
- Монреалын Шүүгчийн хараат бус байдлын талаарх түгээмэл тунхаглал, 1986
- М.Мөнхмандах. Иргэний мэдэх эрх ба төрийн нууцын зохицуулалт, 2011
- ННФ, Дотоод хэргийн их сургууль "Цагдаагийн албаны үйл ажиллагааны журам хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх" судалгааны тайлан, 2020
- Шүүхийн Ерөнхий зөвлөл "Монгол Улсын шүүхийн тайлан 2022 он", УБ, 2023

Гадаад хэл дээрх эх сурвалж:

- Guilherme France, "Transparency of Court Proceedings", 2019
- Nina S. Manova, Marina A. Baranova, Nikita V. Spesivov, "Transparency in Criminal Proceedings: Safeguarding the Interests of Society and State", 2022

-
- Burkhard Hess and Ana Koprivica Harvey, "Open Justice in Modern Societies: What Role for Courts?", *Open Justice: The Role of Courts in a Democratic Society*, Nomos 2019
 - 김진하, “‘민주적’ 법치국가에서의 사법”, 2017년도 법관연수 어드밴스 과정 연구논문집, 사법연수원, 2018
 - 사법정책연구원, 재판공개원칙의 현대적 의미와 한계, 연구총서, 2023
 - House of Commons Justice Committee, *Open justice: court reporting in the digital age /Fifth Report of Session 2022-23/*, 2022
 - Judicial College, *Reporting Restrictions in the Criminal Courts* April 2015 (2016)
 - *R (Mohammed) v Foreign Secretary* [2011] QB 218; *R (Guardian News & Media) v City of Westminster Magistrates Court* [2013] QB 618
 - *R (Guardian News and Media Ltd) v City of Westminster Magistrates' Court (Article 19 intervening)* [2012] EWCA Civ 420; [2013] QB 618
 - *Clibbery v Allen* [2002] EWCA Civ 45
 - Lord Sumption's judgment in *Khuja v Times Newspapers Limited and others* [2017] UKSC 49
 - House of Commons Justice Committee, *Open justice: court reporting in the digital age /Fifth Report of Session 2022-23/* October 2022
 - *Attorney General v Leveller Magazine Ltd* [1979] AC 440, 449-450
 - *R (on the application of C) v Secretary of State for Justice* [2016] UKSC 2
 - *Scott & Anor v Scott* [1913] UKHL 2 (5 May 1913)
 - House of Commons Justice Committee, *Open justice: court reporting in the digital age /Fifth Report of Session 2022-23/* October 2022
 - *R v Sarker* [2018] 1 WLR 6023, per Lord Burnett CJ, at §29(iv)
 - Kolosovich, M.S. (2019). *Procedural means of ensuring transparency and secrecy in criminal proceedings: conceptual foundations (Doctoral Dissertation)*. Volgograd.
 - Manova, N. S., Baranova, M. A., & Spesivov, N. V. (2022). *Transparency in Criminal Proceedings: Safeguarding The Interests Of Society And State*. In S. Afanasyev, A. Blinov, & N. Kovaleva (Eds.), *State and Law in the Context of Modern Challenges*, vol 122. *European Proceedings of Social and Behavioural Sciences*
 - Gunin, D. I. (2008). *Transparency and secrecy of information: a theoretical and legal aspect (Doctoral Dissertation)*. Ekaterinburg.

- Svezhintsev, E. I. (2017). Publicity as a means of public control over the activities of bodies carrying out criminal proceedings: international and Russian Aspects State and Law: Evolution, Modern Condition, Development Prospects (towards the 300th Anniversary of the Russian Police). St. Petersburg.
- UNODC "University Module Series: Anti-Corruption, Module 6: Derecting and Investigating Corruption", 2013
- Council of Europe "Handbook on Transparency and Citizen Participation in Armenia", 2nd edition, 2020
- Stephanos Bibas. Transparency and Participation in Criminal Procedure. 2006. Faculty Scholarship at Penn Carey Law.
- Shusuke Kakiuchi, Minjisaibantetsuduki No ITka -Online Moushitate · Soshoukiroku No Denshika
- [Digitalization of Civil Procedures -Online Filing and Digitization of Case Records], HOURITSU NO HIROBA, Sep 2022
- SAIBAN TETSUDUKITOU NO ITKA KENTOUKAI (IT for Court Proceedings Study Group, Cabinet Secretariat), ITTetsudukitou No ITka Ni Muketa Torimatome [IT Study Group Report for Digitalizing Court Procedures] (Mar 30, 2018)
- An advisory panel on the digitalization of criminal procedures holds a meeting at the Justice Ministry in Tokyo on 4th of December, 2023
- Editorial: Digitizing criminal justice system should ensure civil liberty protections. Komeito. 2022
- Peter Schaar "Freedom of information and transparency in Germany", short paper, 2019

Цахим эх сурвалж:

- Ed Owen (committees.parliament.uk/writtenevidence/40141/html/)
- The Legal Education Foundation (committees.parliament.uk/writtenevidence/41210/html/)
- Нийтэд нээлтэй бус, албан бус эх сурвалжийг оруулав. https://www.academia.edu/38190905/%D0%A6%D0%91%D2%AE%D0%90%D0%96_%D0%BA%D0%BE%D0%B4_pdf
- Анхан шатны шүүхүүдийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=66&pr=61&tp=list&h=0>
- Давж заалдах шатны шүүхүүдийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=67&pr=61&tp=list&h=0>
- Хяналт шатны шүүхийн веб сайт: <https://supremecourt.mn/home?page=pages&id=116&pr=115&tp=list&h=0>

-
- Шүүхийн судалгаа, мэдээллийн төв "Шүүхийн захиргааны чиг үүрэг" харьцуулсан лавлагаа, Цахим холбоос: https://www.judcouncil.mn/file/research/5__%D0%A8%D2%AF%D2%AF%D1%85%D0%B8%D0%B9%D0%BD_%D0%B7%D0%B0%D1%85%D0%B8%D1%80%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D1%8B_%D1%87%D0%B8%D0%B3_%D2%AF%D2%AF%D1%80%D1%8D%D0%B3_%D1%85%D0%B0%D1%80%D1%8C%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D1%81%D0%B0%D0%BD_%D0%BB%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0.pdf
 - <https://legalinfo.mn/mn/detail/374> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцно.
 - https://www.gesetze-im-internet.de/englisch_ifg/englisch_ifg.html#p0013, German Code of Criminal Procedure (Strafprozeßordnung – StPO)
 - https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0015
 - German Code of Criminal Procedure, Section 32d. https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p0015
 - OZG, https://www.gesetze-im-internet.de/ozg/_1.html
 - Criminal Procedure Act
 - <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>
 - https://egvp.justiz.de/beh_allgemeine_info/index.php
 - [https://apps.supremecourt.az.gov/publicaccess/\(X\(1\)S\(oe2qmyejx5oo0riiwxheh55\)\)/caselookup.aspx](https://apps.supremecourt.az.gov/publicaccess/(X(1)S(oe2qmyejx5oo0riiwxheh55))/caselookup.aspx)
 - <https://justizonline.gv.at/jop/web/content/akteneinsicht>
 - <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>
 - <https://fgn.kics.go.kr/en/jsp/cjp/criminalJustice.jsp>
 - <https://www.e-justice.mn/>